

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 11.020

Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа	MNS 5081:2013
Structure and activity of the sum, village's health center	MNS 5081:2001, MNS 5082:2005-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 63 дугаар тогтоолоор батлав.

Стандартыг 2014 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1 Зорилго

Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш, хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангахад оршино.

2 Хэрэглэх хүрээ

Сум, тосгоны болон зэргэлдээ сумын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш, хүртээмжтэй, аюулгүй байдал, чанарыг тасралтгүй сайжруулах, хяналт, үнэлгээ хийх, магадлан итгэмжлэхэд хэрэглэнэ.

3 Норматив эшлэл

Энэ стандартад иш татаж хэрэглэсэн дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтална.

MNS 1140:1987 “Барилга байгууламжид ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ”

MNS 12.097:1991, MNS 12.098-91, MNS 12.101-091 “Ажлын байрны хүчдэлийн түвшин”

MNS 12,013:1991 “Ажлын байрны бичил цаг уурын эрүүл ахуйн хэмжээ”

MNS 4244:1994 “Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага”

MNS 4990:2000 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага”

MNS 5455-1:2005 “Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын бүтэц, үйл ажиллагаа”

MNS 5455-2:2005 “Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ”

MNS 5663-1:2006 “Уламжлалт анагаах ухаан-Үндсэн зургаан өвчний оношилгоо, эмчилгээ”

MNS 4621:2008 “Эрүүл мэндийн технологи. Эмчилгээ, оношлогооны түгээмэл үйлдлүүд”

MNS 900:2010 “Ундны усны эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт”

MNS 6881:2010 “Амаржих газрын бүтэц, үйл ажиллагаа”

MNS 5260:2011 “Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага”

MNS6392:2013 “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага”

“Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04

“Олон нийт иргэний барилга” БНБД 31- 03-03

Албан хэрэгцээнд олгов.
Стандарт, хэмжил зүйн газар.

Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын үндэсний төв. 2018-06-20

“Эмчлэн сэргийлэх газрын барилга” БД 31-115-11 барилгын дүрэм
MNS 6055: 2009 Иргэдийн барилга төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага
MNS 6056: 2009 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар
MNS 5377:2004 “Цогцсын шинжилгээний арга, эмгэг судлалын оношийн бүтэц”
MNS 5488:2005 Эрүүл мэндийн технологи. Үр хөндөлтийн тусламж үйлчилгээ
MNS CAC/RCP 39:2011 Нийтээр нь үйлчлэх хоол, үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал
MNS 4946:2005 Хоолны газрын ангилал, зэрэглэл, шаардлага

4 Тодорхойлолт

4.1

Сум, тосгоны эрүүл мэндийн төв

харьяа нутаг дэвсгэрийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллага;

4.2

Сум дундын эмнэлэг

төрийн захиргааны төв байгууллагаас баталсан шийдвэрийн дагуу хүн амын суурьшил, нягтралаас хамааран харьяалалын болон бусад сумдын хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага;

4.3

Харьяа нутаг дэвсгэрийн хүн ам

харьяаллын хүн ам болон тухайн нутагт амьдарч байгаа хөдөлгөөнт хүн ам.

5 Ангилал

5.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төвийг аймгийн төвөөс алслагдсан байдал, хүн амын тоо, аймгийн төв хүртэлх зорчих хугацаанаас хамааран 3 зэрэглэлд ангилна.

5.1.1 Нэгдүгээр зэрэглэл - Аймгийн төвөөс 50 км-ийн дотор, үйлчлэх хүрээний хүн амын тоо нь 3000 хүртэл Сумын эрүүл мэндийн төв

5.1.2 Хоёрдугаар зэрэглэл - Аймгийн төвөөс 50-99 км-ийн дотор болон 1-2 цаг хүртэлх хугацаанд зорчих Сумын эрүүл мэндийн төв

5.1.3 Гуравдугаар зэрэглэл - Аймгийн төвөөс 100 км-ээс алс, сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэг

5.2 Сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50 км-ээс дотогш боловч, үйлчлэх хүрээний хүн амын тоо 3000-аас дээш, хүн амын 70-аас дээш хувь нь сумын төвөөс алслагдсан бол хоёрдугаар зэрэглэлд,

5.3 Сумын эрүүл мэндийн төв нь 100 км-ээс дотогш боловч үйлчлэх хүрээний хүн амын тоо 8000-аас дээш, хүн амын 70-аас дээш хувь нь сумын төвөөс алслагдсан бол гуравдугаар зэрэглэлд хамааруулна.

6 Бүтэц, зохион байгуулалт, удирдлага

6.1 Бүтэц, зохион байгуулалт

6.1.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь дараах бүтэцтэй байна.

6.1.1.1 Нийгмийн эрүүл мэнд;

- 6.1.1.2 Хэвтүүлэн эмчлэх;
- 6.1.1.3 Оношилгоо;
- 6.1.1.4 Дэмжих үйлчилгээ.

6.1.2 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийг хөгжүүлэх стратеги, ангилал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.2 Удирдлага

- 6.2.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн даргыг хууль, тогтоомжид заасны дагуу сонгон шалгаруулж, эрх бүхий этгээд томилж, чөлөөлнө.
- 6.2.2 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн дарга нь өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн, эрүүл мэндийн удирдлагын сургалтад хамрагдсан байна.
- 6.2.3 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь удирдлагын багтай байна.
- 6.2.4 Удирдлагын багийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг сум/ тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн дарга батлах ба бүрэлдэхүүнд хамт олны төлөөлөл байна.
- 6.2.5 Удирдлага нь эрүүл мэндийн хууль болон бусад эрх зүйн орчин, байгууллагын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг сайжруулахад дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана.

6.3 Төлөвлөлтийн удирдлага

- 6.3.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийг хөгжүүлэх стратеги, аймгийн эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөөнд суурилсан хөтөлбөр, хэтийн төлөвлөгөөтэй байна. Уг хөтөлбөр, хэтийн төлөвлөгөөнд уялдуулан жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээтэй ажиллана.
- 6.3.2 Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь хэтийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулагдсан байна.
- 6.3.3 Төлөвлөгөө нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш байдал, хүртээмж, чанар, аюулгүй байдлыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, аж ахуй, нэгж байгууллага, олон нийт, иргэдтэй хамтын ажиллагааг өрнүүлэхэд чиглэсэн байна.
- 6.3.4 Төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр дүгнэн, үр дүнг сумын Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл, хамт олны хурлаар хэлэлцүүлэн, харьяа дээд шатны байгууллагад тайлагнана.
- 6.3.5 Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, санхүүжилтийн эх үүсвэртэй байна.

6.4 Чанарын удирдлага

- 6.4.1 Тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чанарын удирдлагаар хангах, чанар сайжруулах ажлыг зохион байгуулах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих чиг үүрэг бүхий чанарын алба ажиллана.
- 6.4.2 Чанарын хөгжлийн хөтөлбөр нь тусламж, үйлчилгээний чанар сайжруулах шинэлэг арга хэрэгслийг нэвтрүүлэх, үйлчлүүлэгч, ажилчдын аюулгүй байдлыг хангах, сэтгэл ханамжийг дээшлүүлэх, урамшууллын тогтолцоотой уялдуулахад чиглэнэ.

6.4.3 Чанарын алба нь эмчилгээ, оношилгоо, түгээмэл үйлдлийн стандарт, эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтийг хянан, үр дүнг тооцож ажиллана.

6.4.4 Чанарын алба нь эмчилгээ, оношилгооны болон ёс зүйн алдааг бүртгэх, алдаа гарахаас сэргийлэх, чанарын хяналтын хуудсыг хөтлөн үр дүнг тооцно.

6.4.5 Үйлчүүлэгч, эмч, ажилчдын сэтгэл ханамжийг улирал тутам судлан, дүгнэлт хийнэ.

6.4.6 Удирдлага нь чанарын албаны чадавхийг сайжруулах, чанар, аюулгүй байдлыг хангахад хамт олны тэгш оролцоог бүрдүүлэн, урамшуулан, идэвхжүүлж ажиллана.

6.5 Тусламж, үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдлын удирдлага

6.5.1 Орон нутгийн Засаг даргын тамгын газартай хамтран хүн амын бүртгэл, мэдээлэл, шилжилт хөдөлгөөний нэгдсэн санг ажиллуулан, тасралтгүй байдлыг хангана.

6.5.2 Тусламж үйлчилгээний хүлээгдэл, ачааллыг зохицуулсан цагийн хуваарьтай байна.

6.5.3 Баг, өрхийн байршлын зураглал, холбоо мэдээллийн хэрэгсэл, дуудлага хүлээн авах, бүртгэх, зөвлөгөө өгөх боломж бүрдүүлсэн байна.

6.5.1 Хүн амын эрүүл мэндийн нэгдсэн сан, судалгаатай, зорилтот бүлэгт эрүүл мэндийн хяналт хийх хуваарь нь тодорхой байна.

6.5.1 Үйлчлүүлэгчийг нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд илгээх, лавлагаа мэдээлэл өгөх, бүртгэх, хянах, эргэн магадлах журамтай байна.

6.5.1 Үйлчлүүлэгчдэд нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн зөвлөмжийн дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлж, хяналт тавина.

6.5.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь багийн эмчийг алслагдсан хүн амд хүрч үйлчлэх эм, эмнэлгийн хэрэгслээр бүрэн хангана.

6.6 Хүний нөөцийн удирдлага

6.6.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн хөгжлийн стратегид тулгуурлан хүний нөөцийг хөгжүүлэх, сургалт зохион байгуулах, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааг төлөвлөн, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг хангаж ажиллана.

6.6.2 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь эмнэлгийн мэргэжилтний болон нийтийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, харилцаа ёс зүйн алдаанаас сэргийлж ажиллана.

6.6.3 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий, шаардлагатай хүний нөөцөөр хангагдсан байна.

6.6.4 Эмнэлгийн ажилтан нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан ажлын байрны тодорхойлоход заагдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

6.6.5 Удирдлагын багийн гишүүд нь эмнэлгийн мэргэжилтэнг өрхийн анагаах ухаанаар мэргэших, эмнэлзүйн тойрох сургалт, нийгмийн эрүүл мэнд, зайн сургалт болон бусад сургалтанд хамруулан мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.

6.6.6 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь эмнэлгийн мэргэжилтнийг эмнэлзүйн болон тархварзүйн судалгаа хийх ур чадварт суралцахад дэмжиж ажиллана.

6.6.7 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь хүн амын тоо, өвчлөл, тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээнд тулгуурлан эрүүл мэндийн ажилтанг хавсралтад заасан орон тооны доод хязгаараас доошгүй ажиллуулна.

6.6.8 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн номын сан нь ажилтан мэргэжил, мэдлэг, үйл ажиллагаагаа дээшлүүлэх, интернет ашиглах, зайн сургалтанд хамрагдах боломжийг бүрдүүлсэн байна.

6.7 Санхүүгийн удирдлага

6.7.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн санхүүжилт, санхүүжих арга, төлбөрийн хэмжээ нь холбогдох хууль эрх зүйгээр зохицуулагдана.

6.7.2 Санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох хууль, нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон олон улсын стандартуудыг мөрдөнө.

6.7.3 Хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлангийн үнэн зөв, ил тод байдлыг хангаж, холбогдох байгууллагад тайлагнана.

6.7.4 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь санхүүжүүлэгч байгууллагатай батлагдсан тусламж үйлчилгээний багцын дагуу гэрээ хийж ажиллана.

6.8 Эрсдлийн удирдлага

6.8.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь байгууллагын эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлээс сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ.

6.8.2 Эрсдлээс сэргийлэх нөөц, төсвийг тооцон, төсөвлөлтөнд тусгана.

6.9 Бүртгэл, мэдээллийн удирдлага

6.9.1 Бүртгэл, мэдээллийн нэгж нь мэдээлэл, эргэн мэдээлэл, тайлагналтын бодитой, шуурхай, ил тод байдлыг хангаж ажиллана.

6.9.2 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь байгууллага, үйл ажиллагааны танилцуулгатай байх ба шинэ мэдээллээр тогтмол баяжуулж, үйл ажиллагааг сурталчилна.

6.9.3 Бүртгэл, мэдээлэл цуглуулалт, эргэн мэдээлэл, тайлагналт, хадгалах үйл ажиллагаа нь батлагдсан хууль, стандарт, журмын дагуу явагдана.

6.9.4 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь цахим бүртгэл, мэдээллийн сантай байх ба хүний нөөц, программ хангамж, тоног төхөөрөмжөөр (компьютер) хангагдсан, дотоод сүлжээнд холбогдсон байна.

6.9.5 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь хүн амын эрүүл мэндийн байдал, оношилгоо, эмчилгээ, хяналтын талаар мэдээний нэгдсэн сантай байна.

6.9.6 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь хувь хүн, байгууллагын мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хамгаална.

6.9.7 Олон улсын хөл хориот болон байгалийн голомтот халдварт өвчин, гамшгийн үед шаардлагатай мэдээллүүдийг холбогдох байгууллагуудад тушаал, шийдвэрт заасан хугацаанд мэдээлнэ.

6.10 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн ор

6.10.1 Орны тоо нь сум, тосгоны эрүүл мэндийн төвийн зэрэглэлээс хамааран харилцан адилгүй байна.

6.10.1.1 Нэгдүгээр зэрэглэлийн сум, тосгоны эрүүл мэндийн төв нь нийт 5-7 хүртэл ортой, үүнээс цочмог өвчин болон ажиглалтад зориулсан 1-2 ор, төрөхийн 1 ортой байна;

6.10.1.2 Хоёрдугаар зэрэглэлийн сум, тосгоны эрүүл мэндийн төв нь нийт 7-11 хүртэл ортой, үүнээс цочмог өвчин болон ажиглалтад зориулсан 2-4 ор, төрөхийн 1-2 ортой байна.

6.10.1.3 Гуравдугаар зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь нийт 15-20 хүртэл ортой, үүнээс цочмог өвчин болон ажиглалтад зориулсан 3-4 ор, төрөхийн 2 ортой байна.

6.10.2 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь 2-3 ор бүхий эхийн амрах байртай байна.

6.10.3 Нийт орны 15 хүртэл хувьд өдрийн эмчилгээний ор ажиллуулахыг зөвшөөрнө.

6.10.4 Халдварт өвчин голомтлон гарсан болон гэнэтийн осол, байгалийн гамшиг зэрэг онцгой тохиолдолд зохих шийдвэрийн дагуу орны тоог тодорхой хугацаанд зохицуулна.

7 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

7.1 Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа

7.1.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь харьяа эрүүл мэндийн газраас мэргэжил арга зүйн дэмжлэг авч, нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэн, үр дүнгийн үнэлгээ хийж, төлөвлөлтөнд тусган ажиллана.

7.1.2 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө нь халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, бага насны хүүхэд болон өсвөр үеийнхэний эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэнд, осол гэмтлээс урьчдлан сэргийлэх, орчны эрүүл ахуйг сайжруулах, эмийн зохистой хэрэглээ, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэсэн байна.

7.1.3 Нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг судлах, хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулна.

7.1.4 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд орон нутгийн засаг, захиргаа, аж ахуй, нэгж байгууллага, олон нийт, иргэд, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэнг татан оролцуулна.

7.1.5 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих сайн дурын эрүүл мэндийн бүлэг байгуулан, үйл ажиллагаа, санаачилгыг дэмжиж ажиллана.

7.1.6 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны үр дүнг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн, хамтарч ажиллана.

7.2 Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа

7.2.1 Хүн амын дунд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол явуулж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, дадал болгон хэвшүүлэхэд тусална.

7.2.2 Эрсдэлт зан үйлийг бууруулах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийхэд байгууллага, олон нийт, сайн дурын идэвхтэнг дайчлан, татан оролцуулна.

7.2.3 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжихэд салбар дундын болон олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтын ажиллагааг өрнүүлнэ.

7.2.4 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах сургалтын танхим-номын сантай байна.

7.2.5 Номын сан нь үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгааны материал, гарын авлага, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

7.3 Урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээ

7.3.1 Халдварт өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг

7.3.1.1 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, эмчилгээнд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, эмнэлзүйн удирдамж, түгээмэл үйлдлийн технологийг мөрдөнө.

7.3.1.2 Халдвар хяналтын тогтолцоог бэхжүүлэх, цочмог халдварт өвчний эрсдэлт хүчин зүйл болон шинэ, шинээр сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.3.1.3 Халдварт өвчний эрсдэлт бүлгийн судалгаатай, хяналтанд авсан, мэдээний нэгдсэн сантай байна.

7.3.1.4 Халдварт өвчнөөс сэргийлэх товлот болон сайн дурын дархлаажуулалтанд зохих насны хүн амыг цаг тухайд нь бүрэн хамруулна.

7.3.1.5 Үйлчлүүлэгчийн онош тодорхойгүй, сэжигтэй тохиолдолд төрөлжсөн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авах, онош тодруулах арга хэмжээг авч, эмчлэн сэргийлэхийн зэрэгцээ онош бүрэн батлагдахгүй, өвчний хүндрэлийг эмчлэх боломжгүй тохиолдолд дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад явуулна.

7.3.1.6 Халдварт өвчин гарсан тохиолдолд таслан зогсоох, тусгаарлах, хол хорио тогтоох үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ.

7.3.2 Зонхилон тохиолдох халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг

7.3.2.1 Зонхилон тохиолдох халдварт бус өвчний үзлэг, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, эмнэлзүйн удирдамж, түгээмэл үйлдлийн технологийг мөрдөж ажиллана.

7.3.2.2 Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээг тодорхой төлөвлөлтийн дагуу хийж, үр дүнг тооцно.

7.3.2.3 Халдварт бус өвчний бүртгэл, мэдээний нэгдсэн сангийн үнэн зөв, тасралтгүй байдлыг хангасан байна.

7.3.2.4 Артерийн даралт ихсэх, чихрийн шижин, хөх, умайн хүзүүний хавдар болон бусад зонхилон тохиолдох өвчний урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтын тасралтгүй байдлыг хангаж, үр дүнг тооцно.

7.4 Хүн амын эрүүл мэндийг хянан, эрүүлжүүлэх үйл ажиллагаа

7.4.1 Харьяаллын хүн амын эрүүл мэндийн судалгаанд үндэслэн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хүн амыг эрүүл мэндийн эрсдлийн бүлгээр ангилан хяналтанд авна.

7.4.2 Хүн амын эрүүл мэндэд хяналт тогтоон, урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйл төлөвшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.4.3 Хүн амын эрүүл мэндийн 3-р бүлэгт идэвхитэй хяналт тогтоон, эмчлэн эрүүлжүүлэх, хүндрэлээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.4.4 Хүн амын эрүүл мэндийн 4-5-р бүлэгт байнгын хяналт тогтоон, хүндрэлээс сэргийлэх, амьдралыг уртасгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.4.5 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь хүн амын эрүүл мэндийн бүлэг шилжүүлэлтийн хувийг, ялангуяа 1, 2-р бүлгийн хувийг жил бүр нэмэгдүүлсэн байна.

7.5 Зөвлөгөө өгөх үйлчилгээ

7.5.1 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгч бүрт тохирсон эрүүл мэндийн зөвлөгөөг ойлгомжтой үг хэллэгээр өгнө.

7.5.2 Зөвлөгөө өгөх, ёс зүй, харилцааны ур чадварт эрүүл мэндийн бүх ажилтанг сургаж, ажлын гүйцэтгэл, үнэлгээтэй уялдуулна.

7.6 Нийгмийн хамгаалал, халамжийн болон асаргаа сувилах үйлчилгээ

7.6.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь нийгмийн хамгаалал, халамжийн болон асарч сувилах үйлчилгээг (алслагдсан багаас ирсэн, асрах хүнгүй, өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүчирхийлэлд өртөгсөд) хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлнэ.

7.6.2 Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг тэнхрүүлэх, өвдөлт намдаах, сувилгаа, асаргаа хийх, сэргээн засах, нийгэм сэтгэл зүйн тусламж үзүүлэхэд чиглэнэ.

7.6.3 Үйлчлүүлэгчдэд нийгмийн шинж чанартай тусламж, үйлчилгээг төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан сумын Засаг даргын тамгын газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран үзүүлнэ.

7.7 Ээлтэй үйлчилгээ

7.7.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь архи, тамхигүй эрүүл мэндийг дэмжигч орчинг бүрдүүлэн ажиллана.

7.7.2 Амбулатори, хүлээлгийн хэсэгт үйлчилгээний таатай орчин (телевиз, мэдээллийн самбар, жин, өндөр хэмжигч) бүрдүүлэн, санал хүсэлт, гомдол хүлээн авах, лавлагаа мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлсэн байна.

7.7.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, тэргэнцэртэй хүмүүсийг ээлтэй орчинд үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

7.7.4 Үйлчлүүлэгчдэд лавлагаа мэдээлэл өгөх, ар гэртэй холбоо барих, дуудлага бүртгэх, хариу мэдээлэхэд шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

7.7.5 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь шөнийн цагт гэрэлтэж харагдах таних тэмдэг, галын аюулаас хамгаалагдсан гэрэлтүүлэгчийг гадна талд (өндөрлөг) байршуулсан байна.

7.7.6 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн гадаад орчинг цэцэрлэгжүүлж, таатай орчинг (гэрэлтүүлэг, сандал, сүүдрэвч) бүрдүүлсэн байна.

8 Эмнэлгийн тусламж үйлчилгээ

8.1 Лавлагаа, мэргэжил арга зүйгээр хангагдах

8.1.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь харьяа эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс лавлагаа, мэргэжил арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллана.

8.1.2 Лавлагаа, мэргэжил арга зүйн тусламж, үйлчилгээ нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан шийдвэр, журмаар зохицуулагдана.

8.1.3 Эрүүл мэндийн ажилтанг сургах, ур чадварыг дээшлүүлэхэд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллана.

8.2 Амбулаторийн тусламж, үйлчилгээ

8.2.1 Амбулаториор үйлчлүүлэгчдийн үзлэг, оношилгоо, эмчилгээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж буй стандарт, эмнэлзүйн удирдамжийн дагуу хийнэ.

8.2.2 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь зэрэглэл, үйл ажиллагааны онцлогоос хамааран эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тусламж, үйлчилгээний багцын дагуу тусламж, үйлчилгээг (нүд, мэс засал, амны хөндий... гэх мэт) нэмэлтээр үзүүлнэ.

8.2.3 Сумын иргэдийг иргэний эрүүл мэндийн дэвтрээр бүрэн хангасан байна.

8.2.4 Иргэний эрүүл мэндийн дэвтэрт эрүүл мэндийн бүлэг, дархлаажуулалт, үзлэг, шинжилгээ, оношилгоо, эмчилгээг тэмдэглэн, эрүүл мэндийн байдалд хяналт тавина.

8.2.5 Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь ойролцоох сум дундын эмнэлэг, бусад эрүүл мэндийн төвүүдтэй хамтран хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

8.3 Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ

8.3.1 Хэвтэн эмчлүүлэгчдийн үзлэг, оношилгоо, эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж буй стандарт, эмнэлзүйн удирдамжийн дагуу үзүүлнэ.

8.3.2 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлийн стандартыг эзэмшсэн байна. /MNS 4621:2008/

8.3.3 Өвчин хүндэрсэн, онош тодорхойгүй тохиолдолд эмч нарын хамтарсан үзлэг хийж, оношилгоо, эмчилгээг шийдвэрлэнэ.

8.3.4 Эмчлүүлэгчийн үзлэг, оношийн үндэслэл, шинжилгээ, эмчилгээг өвчний түүхэнд стандартын дагуу тэмдэглэнэ.

8.3.5 Эмчлүүлэгчийг эмнэлгээс гарахад нь эмчлэгч эмч өвчний явц, эдгэрэлт, хяналтын талаар мэдээлэл, зөвлөлгөө өгч, иргэний эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ.

8.3.6 Мэргэжлийн эмчээс зөвлөгөө авах, сум дундын болон аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвд шилжүүлэх арга хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батласан журмын дагуу шийдвэрлэнэ.

8.3.7 Үйлчлүүлэгчийг нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд шилжүүлэхдээ эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам болон эмнэлзүйн удирдамжийг баримтлана.

8.3.8 Нийгмийн эрүүл мэндэд ноцтой аюултай өвчин эмгэг гарсан тохиолдолд өвчтөнийг тусгаарлан (амьсгалын болон гэдэсний халдварын) эмчлэх боломж нөхцлийг хангасан байна.

8.4 Оношилгоо

8.4.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь мэргэшсэн хүний нөөц, хавсралтанд заасан оношлуур, багаж, тоног төхөөрөмжтэй байна.

8.4.2 Лаборатори нь сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлээс хамааран клиник-гематологи, клиник-биохими, иммунологийн, (түргэвчилсэн) серологийн (ийлдэс судлалын) шинжилгээг батлагдсан стандарт, удирдамжийн дагуу хийнэ.

8.4.3 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь зүрхний цахилгаан бичлэг, хэт авиан оношилгоо хийх ба 3-р зэрэглэлийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь үйлчлэх хүрээ, хүчин чадлаасаа хамааран рентген шинжилгээ хийнэ.

8.4.4 Оношилгооны хэсэгт халдвар хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж, чанарын дотоодын хяналт хийнэ.

8.4.5 Лаборатори нь жил бүр чанарын гадаад үнэлгээ хийлгэсэн байна.

8.5 Сувилахуйн тусламж, үйлчилгээ

8.5.1 Сувилахуйн тусламж, үйлчилгээнд батлагдсан стандарт, эмнэлзүйн удирдамж, түгээмэл үйлдлийн технологийг мөрдөж ажиллана.

8.5.2 Ахлах сувилагч нь асаргаа, сувилахуйн тусламж үйлчилгээг мэргэжил арга зүйгээр хангаж, сувилагч бусад мэргэжилтнүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулна.

8.5.3 Чанарын алба нь сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлэхэд дэмжиж ажиллана.

8.6 Сэргээн засах, чийрэгжүүлэлтийн тусламж, үйлчилгээ

8.6.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь олон нийтэд түшиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээг батлагдсан стандарт, технологи, удирдамж, аргачлалын дагуу үзүүлнэ.

8.6.1 Хүн амын дунд бие бялдар, эрүүл мэндийн сорил, үнэлгээг жил бүр хийж, биеийн тамир чийрэгжүүлэлтийн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

8.6.1 Сэргээн засах, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа, нэр төрлийг нэмэгдүүлэн, үр дүнг тооцох ба шаардлагатай хүний нөөц, багаж, тоног төхөөрөмж, өрөөгөөр хангагдсан байна.

8.7 Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ

8.7.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг “Уламжлалт анагаах ухаан-Үндсэн зургаан өвчний оношилгоо, эмчилгээ” болон бусад батлагдсан стандарт, удирдамж, аргачлалын дагуу хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлнэ.

8.7.2 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэн, тусламж, үйлчилгээний хүртээмж, үр дүнг нэмэгдүүлнэ.

8.7.3 Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, тоног төхөөрөмж, эм хэрэгслээр хангагдсан байна.

8.8 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

8.8.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллана.

8.8.2 Эх барих, эмэгтэйчүүдийн үзлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтыг батлагдсан стандарт, эмнэлзүйн удирдамж, түгээмэл үйлдлийн технологийн дагуу хийж, мэдээний нэгдсэн санг үүсгэн, тасралтгүй байдлыг хангана.

8.8.3 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь эх барихын яаралтай тусламж үзүүлэх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна.

8.8.4 Жирэмсэнтэй хавсарсан өвчлөлийг эрт илрүүлэх, хүндрэлээс сэргийлэх, хянах, мэргэжлийн эмчийн хяналтанд төрүүлэхэд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, эмнэлзүйн удирдамжийг мөрдөнө.

8.8.5 Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээг төлөвлөгөөний дагуу хийж, үр дүнг тооцно.

8.8.6 Жирэмсэн эмэгтэйчүүдийг хянах, төрөлт удирдах, эх барих, яаралтай тусламж үзүүлэх чадавхи, бэлэн байдлыг хангасан байна.

8.8.7 Жирэмсэн эмэгтэйн цусны бүлгийг тодорхойлох, төрөлтөнд бэлтгэх, төрсөн эх, нярайг гэрийн эргэлтээр хянах, зөвлөгөө өгөх, эхийн амрах байранд амруулах үйлчилгээг эмч, эх баригч эмч үзүүлнэ.

8.8.8 Гэр бүл төлөвлөлтийн сургалтанд нөхөн үржихүйн насны иргэд болон залуу гэр бүлийг хамруулан, зөвлөгөө өгч, төрөлт хоорондын хугацааг зохицуулах мэдлэг олгож, гарын авлага, жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгсэл түгээнэ.

8.8.9 Сум дундын эмнэлэгт үр хөндөлтийн тусламж үйлчилгээг холбогдох хууль, стандартаар зохицуулна. MNS 5488:2005

8.8.10 Эмнэлгийн мэргэжилтэн нь үр хөндөлтийн өмнөх болон дараах зөвлөгөө өгч, үр хөндүүлсэн эмэгтэйд илэрч болох хүндрэлийг эрт илрүүлэн холбогдох тусламжийг үзүүлнэ.

8.9 Хүүхэд, өсвөр үеийн тусламж, үйлчилгээ

8.9.1 Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж буй стандарт, эмнэлзүйн удирдамж болон хүүхдийн өвчний цогц менежментийн дагуу үзүүлнэ.

8.9.2 Хүүхэд, өсвөр үеийнхний насны онцлогоор нүд, амны хөндий, чих, хамар хоолой, сэтгэцийн эрүүл мэндийн болон бусад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ хийж, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авна.

8.9.3 Дархлаажуулалтыг товллын дагуу хийж, хамралтыг зохих шийдвэр, журмын дагуу мэдээлнэ.

8.9.4 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь хүүхдийн эрүүл хооллолтын талаар зөвлөгөө өгч, хооллолтын бэрхшээлтэй хүүхдийг илрүүлж, эрүүлжүүлэх арга хэмжээ авна.

8.9.5 Өсвөр насны хүүхдүүдийг хорт зуршил, нөхөн үржихүй-бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдээлэл, сургалтанд хамруулан, үзлэг, шинжилгээ хийж, зөвлөгөө өгнө.

8.9.6 Өсвөр үеийнхэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөхөд хувь хүний нууцлалыг хадгалж, ээлтэй орчин нөхцлийг бүрдүүлсэн байна.

8.10 Ахмад настны тусламж, үйлчилгээ

8.10.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь Монгол улсын хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратегийг хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллана.

8.10.2 Насжилт, настны эмнэлзүйн удирдамжболон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эмчилгээ, оношилгооны стандарт, эмнэлзүйн удирдамжийн дагуу ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

8.10.3 Эрүүл мэнд, нийгмийн халамж шаардлагатай ахмад настанг гэрээр эргэж, эмчилгээнд хяналт тавин, сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

8.10.4 Хяналтанд байдаг ахмад настны асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийг асаргаа, сувилгаа, сэргээн засах дасгал хөдөлгөөний сургалтанд хамруулна.

8.10.5 Хөдөлгөөн, зохистой хооллолтыг өөрсдийн амьдралд нэвтрүүлж, эрүүл мэнддээ анхаарал тавьж байгаа ахмадуудыг урамшуулах, үлгэр дууриал болгох, олон нийтэд сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.

8.11 Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

8.11.1 Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эмгэгийн эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо хийж, оношийг баталгаажуулан, эмчилгээ, хяналтыг бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвтэй хамтран хийнэ.

8.11.2 Сэтгэцийн эмгэг, мансуурах, архинд донтох өвчтэй иргэдийн ар гэрийнхэнд сургалт зохион байгуулж, бие даах, нийгэмшүүлэхэд орон нутгийн засаг захиргааны нэгжтэй хамтран ажиллана.

8.11.3 Архи, тамхины хяналтыг сайжруулах талаар төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн бус байгууллагын санал санаачлагыг дэмжих, мэргэжил арга зүйгээр ханган, иргэнийг архи, тамхинаас гаргахад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх, дам тамхидалтаас сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

8.12 Осол гэмтлийн тусламж, үйлчилгээ

8.12.1 Осол гэмтлээс сэргийлэх үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргаа, сургууль, цагдаа, олон нийт, хамт олныг татан оролцуулж, хамтран ажиллана.

8.12.2 Осол гэмтлийн тусламж, үйлчилгээг зохих стандарт, эмнэлзүйн удирдамж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагаас баталсан журмын дагуу үзүүлнэ.

8.12.3 Эмнэлгийн мэргэжилтэн нь осол гэмтлийн үед эмнэлгийн анхан шатны яаралтай тусламж үзүүлэх сургалтанд хамрагдсан, ур чадвар эзэмшсэн байна.

8.13 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ

8.13.1 Хөнгөвчлөх эмчилгээний тусламж үйлчилгээнд “Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ” -ний стандартыг мөрдөж ажиллана.

8.13.2 Гэрээр сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, өвдөлт намдаах эмчилгээ хийхдээ батлагдсан стандарт, заавар, журмыг мөрдөнө.

8.13.3 Хөнгөвчлөх эмчилгээтэй үйлчлүүлэгчийн ар гэрийхэнд зөвлөгөө өгч, сувилгаа, асаргааны талаар мэдлэг, дадлага, арга зүйн сургалт явуулна.

8.14 Яаралтай, түргэн тусламж, үйлчилгээ, алсын тусламж, үйлчилгээ

8.14.1 Яаралтай, түргэн тусламжийн үйлчилгээ нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэр, журмын дагуу зохицуулагдана.

8.14.2 Цочмог өвчин, эмгэг, осол, гэмтэл, хордлого, төрөх үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх яаралтай тусламж - эрчимт эмчилгээний өрөөтэй байх ба нэн шаардлагатай яаралтай тусламжийн эм, хэрэгсэл, вакцин (татрангийн эсрэг - сум дундын эмнэлэгт), ороох боох материалаар хангагдсан байна.

Эмнэлгийн мэргэжилтэн бүр яаралтай тусламж үзүүлэх сургалтад хамрагдаж, яаралтай тусламж үзүүлэх ур чадвар эзэмшсэн байна.

8.14.3 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь хүүхэд насанд хүрэгчдийн амилуулах суурь тусламж, зүрх болон ослын суурь лавшруулсан тусламж үзүүлэх чадавхитай, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

8.14.4 Онцгой байдал, гамшиг, яаралтай тохиолдлын үед цахим технологи ашиглан зайн оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авах боломж, нөхцөлөөр хангагдсан байна.

8.14.5 Халдварт өвчний дэгдэлт, олныг хамарсан гамшиг, осол зэрэг онцгой байдал үүссэн үед яаралтай тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангасан байна.

8.14.6 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь түргэн тусламж, алсын дуудлагын үйлчилгээ үзүүлэх журамтай байна.

8.14.7 Туулах чадвар сайтай, хүнд өвчтөн тээвэрлэх боломжтой түргэн тусламжийн автомашинтай байна.

8.14.8 Түргэн тусламжийн автомашин нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу тоноглогдсон, таних тэмдэгтэй, яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, холбоо мэдээллийн хэрэгслээр хангагдсан байна.

8.14.9 Автомашины ашиглалт, эдэлгээ, засвар үйлчилгээний судалгааг жил бүр гаргаж, шинэчлэл хийнэ.

8.14.10 Алсын дуудлагын автомашиныг шатахуун, сэлбэг, хэрэгсэл, тослох материалаар тасралтгүй хангах асуудлыг сумын засаг дарга, төвийн дарга гэрээгээр зохицуулна.

8.14.11 Багийн эмч нь алслагдсан иргэдэд хүрч үйлчлэх унаа, шатахуун, сэлбэг хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

8.15 Гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

8.15.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь гамшиг, онцгой байдал, газар хөдлөлтийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөө, зураглалтай, жил бүр тодотгол хийсэн байна.

8.15.2 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь гамшиг, онцгой байдлын үед хийх ажил үүргийн хуваарьтай, сургагдаж бэлтгэгдсэн байна.

8.15.3 Байгууллага нь болзошгүй гамшиг, газар хөдлөлт, онцгой байдлын үед эмнэлгийн аюулгүй байдал (барилга байгууламж, цахилгаан, усан хангамж, сантехник, дулаан гэх мэт), найдвартай ажиллагааг хангаж ажиллана.

8.15.4 Гамшиг, онцгой байдлын үед ажиллуулах нэмэлт хүний нөөц (эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажиллагсад)-ийн нэрийн жагсаалт, хаяг, холбоо барих утсыг гаргаж, жил бүр шинэчлэн баталсан байна.

8.15.5 Гамшиг, онцгой байдал, болзошгүй аюулаас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг тодорхой төлөвлөгөө, үе шаттайгаар зохион байгуулна.

8.15.6 Гамшиг, онцгой байдлын үед нийтэд мэдээлэх дуут болон гэрлэн дохиолол, чанга яригч, холбоо мэдээллийн хэрэгслээр хангагдсан байна.

8.15.7 Орон нутгийн засаг, захиргааны болон бусад байгууллагатай хамтран гамшгийн бэлэн байдлын дадлага, сургуулилалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

8.16 Эмгэг судлалын тусламж үйлчилгээ

8.16.1 Эмгэг судлалын шинжилгээ, оношилгоог батлагдсан стандартын дагуу гүйцэтгэнэ. (MNS 5377:2004)

8.16.2 Цогцос хадгалах өрөө нь шавьж, мэрэгч амьтан орохооргүй, цонх нь нэвт харагддаггүй байна.

8.16.3 Цогцос хадгалах өрөө нь агааржуулалт сайтай, хөргөгч, бусад шаардлагатай эд хэрэгсэл, гар ариутгах нөхцөлөөр хангагдсан байна.

8.16.4 Цогцос хадгалах, ар гэрт хүлээлгэн өгөх үйлчилгээ нь ёс заншлыг дээдэлсэн байна.

8.16.5 Үдэх ёслолын өрөөг тохижуулж, ёслолын орчин бүрдүүлсэн байна.

9 Стандартын хэрэгжилтийн хяналт, шинжилгээ үнэлгээ

Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтэд дотоодын хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцож чанарын ахиц гаргана.

10 Үнэлгээний үр дүнгийн шалгуур

10.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ ба чанарын үр дүн

10.1.1 Хүн амын эрүүл мэндийн индекс 40 хувиас доошгүй байна.

10.1.2 Гэрийн идэвхитэй эргэлтийн хувь 30 хувиас доошгүй байна.

10.1.3 Бүртгэгдсэн хүн амын нийт нас баралт улсын дунджаас ихгүй байна.

10.1.4 Бүртгэгдсэн хүн амын урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн хувь урд оноос нэмэгдсэн байна.

10.1.5 Уламжлалт, сэргээн засах тусламж, үйлчилгээний нэр төрөл, хамрах хүрээ нэмэгдсэн, иргэдийн сэтгэл ханамж тогтмол сайжирсан байна.

10.1.6 Яаралтай, түргэн тусламжийн үйлчилгээг хугацаа алдалгүй шуурхай үзүүлсэн тусламжийн тоо нэмэгдсэн байна.

10.1.7 Хүн ам, эмнэлгийн мэргэжилтний сэтгэл ханамжийн судалгааны үр дүн урд оноос сайжирсан байна.

10.1.8 Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалтай холбоотой санал, гомдол буурсан, гараагүй байна.

10.1.9 Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх зөвлөгөө өгсөн үйлчлүүлэгчийн тоо өмнөх жилээс өссөн байна.

10.1.10 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой бүртгэгдсэн алдаа, зөрчлийн тоо буурсан байна.

10.2 Тусламж, үйлчилгээний хүртээмжийн үр дүн

10.2.1 Иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд жил бүр хамруулж, “Иргэний эрүүл мэндийн дэвтэр”-т тэмдэглэсэн байна.

10.2.2 Артерийн даралт хэмжих, цусны чихрийн хэмжээг тодорхойлох, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэх үзлэгт хамруулсан хувь 65 хувиас доошгүй байна.

10.2.3 Төв нь отор нүүдлээр яваа малчид болон харьяалалгүй түр оршин суугаа иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, тэгш хүргэнэ.

10.3 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны үр дүн

10.3.1 Хүн амын өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлсийн талаар тандалт судалгаа хийж, үнэлгээ өгсөн байна.

10.3.2 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд засаг, захиргаа, олон нийтийн байгууллага, иргэд, сайн дурын идэвхтэний оролцоо нэмэгдсэн байна.

10.3.3 Эрүүл мэндийг дэмжигч хувь хүн, хамт олон, байгууллагын тоо жил бүр нэмэгдсэн байна.

10.3.4 Үйлчлэх хүрээний хүн амын хоол хүнс, ундны усны аюулгүй байдалд засаг захиргааны нэгжтэй хамтран үнэлгээ хийж, үр дүнг тооцсон байна.

10.3.5 Айл өрхийн бохир ус, хог хаягдлын эрүүл ахуйн байдалд үнэлгээ хийж, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

10.3.6 Дархлаажуулалтын хамрагдалт 96 хувиас доошгүй, урд оноос нэмэгдсэн байна.

10.3.7 Эрүүл зөв хооллолт, дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсдийн тоо жил бүр нэмэгдсэн байна.

10.3.8 Хүн амын Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих мэдлэгийн түвшин урд оноос нэмэгдсэн байна.

10.3.9 Тамхи татдаг, согтууруулах ундаа хэрэглэдэг хүмүүсийн тоо жил бүр буурсан байна.

10.3.10 Эмийн зохистой хэрэглээний үр дүнг тооцсон байна.

10.4 Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааны үр дүн

10.4.1 Нийт хүн амын 70-аас доошгүй хувийг эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт, сурталчилгаанд хамруулсан байна.

10.4.2 Үйлчлэх хүрээний хүн амын дундах сайн дурын идэвхтэн, туслагчийн тоо жил бүр нэмэгдсэн байна.

10.4.3 Сургалт, сурталчилгаа явуулах шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

10.4.4 Номын сан шаардлагатай ном гарын авлага, сургалт, сурталчилгааны материалаар хангагдсан, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.

10.5 Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үр дүн

10.5.1 Нийт халдварт өвчний тохиолдол аймаг, улсын дунджаас доогуур, буурсан байна.

10.5.2 Цочмог халдварт өвчин гарсан тохиолдол бүрт голомтын арга хэмжээг цаг тухайд нь авч, тархалтаас сэргийлсэн байна.

10.5.3 Сүрьеэ, бруцеллёз, бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ тогтмолжсон, эмчилгээнд хяналт тавин, үр дүнг тооцсон байна.

10.5.4 Эмнэлгээс шалтгаалсан халдвар гараагүй байна.

10.5.5 Халдварт өвчний эрсдэлт бүлгийн судалгаа бүрэн хөтлөгдсөн, хяналт сайжирсан байна.

10.5.6 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа тогтмол явуулсан байна.

10.6 Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үр дүн

10.6.1 Зонхилон тохиолддог халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээг стандарт, удирдамж, заавар, журмын дагуу оношилж, эмчлэн, хянасан байна.

10.6.2 Халдварт бус өвчний бүртгэл, судалгаа бүрэн хөтлөгдсөн байна.

10.6.3 Артерийн даралт ихсэх, чихрийн шижин, хөх, умайн хүзүүний хавдар өвчний оношилгоо, эмчилгээ, хяналтын үр дүн тогтмол нэмэгдсэн байна.

10.6.4 Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөний мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулж, үр дүнг тооцсон байна.

10.6.5 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж сайн байна.

10.7 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үр дүн

10.7.1 Эхний 3 сартай жирэмсний хяналтанд орсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь жил бүр нэмэгдсэн байна.

10.7.2 Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтын хувь 70 хувиас доошгүй, жил бүр нэмэгдсэн байна.

10.7.3 Гэр бүл төлөвлөлтийн сургалт, арга хэмжээнд хамрагдсан залуу гэр бүлийн хувь жил бүр 60 хувиас доошгүй, нэмэгдсэн байна.

10.7.4 Эх барих, яаралтай тусламж, үйлчилгээг хугацаа алдалгүй үзүүлсэн, зохих стандарт, эмнэл зүйн удирдамжийн дагуу оношилгоо, эмчилгээ, хяналтыг хийсэн байна.

10.7.5 Эх, нярайг эхний 1 сарын дотор 7 хоног бүр 100 хувь үзсэн байна.

10.7.6 Эхийн эндэгдэл улс, аймгийн дунджаас доогуур, гараагүй байна.

10.7.7 Нярайн нас баралт, амьгүй төрөлт улс, аймгийн дунджаас доогуур байна.

10.8 Хүүхэд, өсвөр үеийн тусламж, үйлчилгээний үр дүн

10.8.1 Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хугацаа алдалгүй үзүүлсэн, зохих стандарт, эмнэлзүйн удирдамжийн дагуу оношилгоо, эмчилгээ, хяналтыг хийсэн байна.

10.8.2 1 хүртэлх насны хүүхдийн хяналт 95 хувь, 1-5 насны хүүхдийн хяналт 80 хувиас тус тус доошгүй, жил бүр өссөн байна.

10.8.3 Хүүхдийн эрүүл мэндийн индекс 70 хувиас доошгүй, жил бүр сайжирсан байна.

10.8.4 Хүүхдийн эндэгдлийн түвшин, халдварт өвчний тохиолдол гаралт буурсан байна.

10.8.5 6 сар хүртэл хүүхдийг хөхөөр бойжуулсан хувь жил бүр 85%-иас доошгүй, нэмэгдсэн байна.

10.8.6 Хүүхэд, өсвөр насныханы нүд, шүд, амны хөндий, хамар хоолойн эрүүл мэндийн үзүүлэлт жил бүр сайжирсан байна.

10.8.7 Бага насны хүүхдүүд болон өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг насны онцлогоор зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.

10.9 Ахмад настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үр дүн

10.9.1 Ахмад настны 70 хувиас доошгүй хувийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, үр дүнг тооцсон байна.

10.9.2 Хэвтрийн, хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн ахмад настанг 100 хувь хяналтанд авсан байна.

10.9.3 Ахмад настны гэрийн болон өдрийн, сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байна.

10.10 Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүн

10.10.1 Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, хүртээмж сайжирсан байна.

10.10.2 Архи хэтрүүлэн хэрэглэдэг, архинд донтсон хүмүүсийн дунд зохион байгуулсан сургалт, сурталчилгааны нэмэгдэж, хэрэглэгчдийн тоо буурсан байна.

10.10.3 Тамхины хяналт, дам тамхидалтаас сэргийлэх үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирсан байна.

10.10.4 Сэтгэцийн эрүүл мэнд, архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээний талаар бусад байгууллага, хувь хүнтэй хамтран ажиллах нөхцөл бүрдсэн байна.

10.11 Яаралтай, түргэн тусламжийн үр дүн

10.11.1 Яаралтай тусламж, үйлчилгээг дуудлага авснаас хойш 30 минутын дотор гарсан байна.

10.11.2 Яаралтай тусламжийн эм эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрэн хангасан байна..

10.11.3 Алсын түргэн тусламжийн туулах чадвар сайтай машинтай, бэлэн байдлыг хангасан байна.

10.11.4 Жолооч анхны тусламж үзүүлэх чиглэлээр сургагдсан байна.

10.12 Гамшиг, онцгой байдлын үеийн тусламж, үйлчилгээний үр дүн

10.12.1 Ажлын байранд гамшиг ослоос сэргийлэх, хамгаалах нөхцлийг бүрдүүлэн, төлөвлөгөөний дагуу ажиллаж, эмнэлгийн аюулгүй байдлын үнэлгээ хийсэн байна.

10.12.2 Гамшиг, онцгой байдлын үед авах арга хэмжээ, бэлэн байдлыг хангасан нэн шаардлагатай, амин чухал эмийн нөөцийн гэрээтэй, нөөцтэй байна.

10.12.3 Гамшиг, онцгой байдлын үед авах арга хэмжээний бүдүүвч зургийг ил тод байршуулан, хамт олон мэддэг болсон байна.

10.12.4 Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдлын сургалтанд бүх ажилтан хамрагдсан, зохих ур чадварыг эзэмшсэн байна.

10.12.5 Гамшиг, онцгой байдлын үед ашиглах ажиллагсад болон хэвтэн эмчлүүлэгчдэд зориулсан 3 доошгүй хоногийн цэвэр ус, хүнсний нөөцтэй байна.

10.12.6 Осол, гэмтлээс сэргийлэх арга хэмжээг тогтмолжуулан, анхан шатны тусламж үйлчилгээг зөв зохион байгуулж, нас баралтыг бууруулсан байна.

11 Дэмжих үйлчилгээ

11.1 Эмзүйн тусламж үйлчилгээ

11.1.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь эм зүйн тусламж үйлчилгээг “Эмийн санд тавих нийтлэг шаардлага” стандартын шаардлага хангасан эмийн сангаар гүйцэтгүүлнэ.

11.1.2 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан зайлшгүй шаардлагатай ба яаралтай тусламжийн эмийн нөөцтэй байна.

11.1.3 Улсын бүртгэлд бүртгэгдсэн чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, эмийн зохистой хэрэглээг хэвшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх үйл ажиллагааг хангаж, үр дүнг тооцож ажиллана.

11.1.4 Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, нөөц, чанар, эмийн зохистой хэрэглээ, захиалга, зарцуулалтанд төвийн дарга өдөр тутам хяналт тавина.

11.2 Цус, цусан бүтээгдэхүүний үйлчилгээ

11.2.1 Яаралтай цус сэлбэх (төрөх, осол гэмтэл, мэс засал) тохиолдолд бүхэл цус цуглуулж, батлагдсан стандарт, дүрэм, журам, зааврыг мөрдөж, эмчилгээнд хэрэглэнэ.

11.2.2 Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй, бэлэн байдлыг хангах үүрэг, хариуцлагыг сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн дарга хүлээнэ.

11.2.3 Сумын улаан загалмай болон олон нийтийн байгууллагатай хамтран донорын сургалт, сурталчилгааг зохион байгуулна.

11.2.4 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь цусны донорын шалгуур үзүүлэлтийн дагуу эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийж, цусны АВО бүлэг тус бүрээс 4-5 донортой байна.

11.2.5 Цус цуглуулах хүүдий, цус сэлбэлтээр дамждаг халдвар илрүүлэх түргэвчилсэн оношлуур, цусны АВО, резус, келл бүлэг тодорхойлох моноклон эсрэг бие агуулсан оношлуур ийлдэстэй байна.

11.2.6 Эмнэлгийн мэргэжилтэн нь цус цуглуулах, цусны бүлгүүд тодорхойлох, цус сэлбэлтээр дамждаг халдвар илрүүлэх шинжилгээ хийх, цус сэлбэх аюулгүй ажиллагааг хангах аргачлалд сургагдсан, ур чадвар эзэмшсэн байна.

11.2.7 Үндэсний удирдамжийг чанд мөрдөж, цусыг зохистой хэрэглэнэ.

11.2.8 Цусны аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааны тайлан мэдээг зохих журмын дагуу цаг хугацаанд нь бүрэн, үнэн зөв гарган мэдээлнэ.

11.2.9 Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэлийг зохих журмын дагуу бүртгэж, мэдээлэх, сэргийлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.

11.3 Багаж, тоног төхөөрөмжийн хангамж, засвар үйлчилгээ

11.3.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь стандартад заасан багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна.

11.3.2 Багаж, тоног төхөөрөмжийн техникийн болон, чанарын баталгаажуулалтын баримт бичгийг бүрдүүлэн, хэвийн, аюулгүй ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх төлөвлөгөөтэй ажиллана.

11.3.3 Жил бүр аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэгт захиалга өгч, нэгдсэн журмаар засвар үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэн, хэвийн, аюулгүй ажиллагааг хангаж, баталгаажуулж ажиллана.

11.3.4 Багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, үзлэг тохиргоо, засвар үйлчилгээ хийсэн бүртгэл тэмдэглэлийг бүрэн хөтлөнө.

11.3.5 Эрүүл мэндийн бүх ажилтанд багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны талаар сургалт явуулж, холбогдох заавар, журмаар хангана.

11.3.6 Тусгай нөхцөл шаардлагатай техник хэрэгслийг хэвийн, аюулгүй ажиллагааг хангах нөхцлийг бүрдүүлсэн хэсэгт байршуулсан байна.

11.4 Аж ахуйн хангамж, үйлчилгээ

11.4.1 Хатуу зөөлөн эдлэлийн хангалт, ашиглалт

11.4.1.1 Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчдийн тав тухыг хангасан, зориулалтын материалаар хийгдсэн зөөлөн эдлэл, угаалга, цэвэрлэгээ ариутгалын шаардлага хангасан тавилга, хэрэгсэлтэй байна.

11.4.1.2 Эмч, ажилчдын нормын хувцас, хэрэглэлийн ашиглалт, хангалтанд зохих заавар, журам, эрүүл ахуйн шаардлагыг мөрдөх ба хувцас нь сайн чанарын хөвөн бөс материалаар хийгдсэн, өнгө, таних тэмдгээр ялгах боломжтой байна.

11.4.1.3 Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэл нь эрүүл ахуйн шаардлага хангасан, хөвөн бөс даавуу буюу цайвар ягаан, цайвар шаргал, цайвар ногоон гэх мэт ууссан өнгөтэй байна.

11.4.1.4 Ор нь тоос, чийг татдаггүй, жигд гадаргуутай гудастай, угааж цэвэрлэхэд хялбар, өнгө үзэмжтэй, бат бөх хийцтэй ширээ, сандал, шүүгээтэй байна.

11.4.1.5 Зөөлөн эдлэлийн чанарт жил бүр тогтмол шалгалт хийж, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон эд зүйлийг холбогдох журмын дагуу эд хөрөнгийн бүртгэлээс хасч, шинээр нөхөн хангалт хийнэ.

11.5 Гал тогоо, хоол хүнс

11.5.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь гал тогооны хэсэгтэй, мэргэшсэн хүний нөөцтэй байна.

11.5.2 Гал тогооны хэсэг нь зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, агуулах бусад шаардагдах өрөө, тасалгаа, эд зүйлээр хангагдсан байна.

11.5.3 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь батлагдсан удирдамж, технологийн дагуу бэлтгэсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан хоолоор үйлчилнэ. (MNS CAC/RCP 39:2011)

11.5.4 Гал тогооны цэвэрлэгээ, үйлчилгээ, хоолны нэр төрөл, бэлтгэн нийлүүлэлт, хоол, хүнсний аюулгүй байдалд удирдлагын болон чанарын алба дотоодын хяналтыг тогтмол хийнэ.

11.6 Угаалга, цэвэрлэгээ

11.6.1 Угаалгын хэсэг нь бохир зүйл хүлээн авах, ялгах, угаах, хатаах, индүүдэх, түр хадгалах, түгээх гэсэн зөв урсгалыг зохицуулсан, эрүүл ахуй, халдвар хамгааллын шаардлага хангасан өрөө, тасалгаа, хүний нөөц, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

11.6.2 Зөөлөн эдлэл болон ажилтны ажлын хувцас, хэрэгслийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тушаал, журмын дагуу угааж, индүүддэг байна.

11.6.3 Халдвартай бүсийн угаалга, цэвэрлэгээнд халдвар хамгааллын дэглэм, техникийн аюулгүй ажиллагааг баримтална.

11.6.4 Халдваргүй бүсийн угаалга, цэвэрлэгээ, үйлчилгээг хуваарийн дагуу эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

11.6.5 Үйлчилгээний ажилчдыг хувцас хэрэгсэл, ахуйн бээлий, тэргэнцэр, халдваргүйтгэлийн бодис, материалаар холбогдох нормын дагуу бүрэн хангана.

11.6.6 Эмчлүүлэгч эмнэлгээс гарсаны дараа хөнжил, гудас, дэрийг тусгай зориулалтын төмөр сууринд тохон, саваадан агаар оруулах нөхцлийг бүрдүүлэн, наранд 2-3 цаг тавьж, физикийн аргаар цэвэрлэнэ.

11.6.7 Орны бүтээлэг, гудас, гудасны уут, хөнжлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тушаал, журмын дагуу цэвэрлэж халдваргүйтгэнэ.

11.6.8 Тоног төхөөрөмжүүд нь хөдөлмөр аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байрлалд суурилуулсан байна.

11.7 Ариутгал, халдваргүйтгэл

11.7.1 Халдваргүйтгэл, ариутгалд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тушаал, зааврыг мөрдөж ажиллана.

11.7.2 Ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаа явуулах мэргэшсэн хүний нөөцтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангаж байршуулсан тоног төхөөрөмжтэй байна.

11.7.3 Ажилтан нь ариутгал, халдваргүйтгэлийн техникийн шаардлага, аюулгүй ажиллагааны стандартыг бүрэн хангаж ажиллана.

11.7.4 Чанарын алба нь багаж, хэрэгсэл, материал, тоног төхөөрөмжийн угаалга, цэвэрлэгээ, халдваргүйтгэл, ариутгалын чанарт тогтмол хяналт тавина.

11.8 Хог хаягдал

Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмыг мөрдөж ажиллана.

12 Эрүүл ахуйн шаардлага

12.1 Орчны эрүүл ахуйн шаардлага

12.1.1 Барилга байгууламж нь хүн амын суурьшлын бүсээс зонхилох салхины доод зүгт, агаар дуслын халдвар, байгалийн голомтот, зоонозын халдварт өвчин тархах эрсдлээс сэргийлэн орон сууц, гэр хорооллоос 100 метрээс хол зайд, бусад барилга, байгууламжаас тусгаарласан хашаатай байна.

12.1.2 Барилга байгууламж нь сумын эмнэлгийн зориулалтынбарилгын зураг төслийн дагуу баригдаж улсын комиссын дүгнэлт, зөвшөөрлөөр ашиглалтанд оруулсан барилга байна.

12.1.3 Барилга байгууламж нь 1-2 га-гаас багагүй эдэлбэр газартай, баталгаажсан кадастрын зурагтай байна.

12.1.4 Төвийн эдэлбэр газрын 60 хувиас багагүй талбай нь ногоон байгууламжтай байна.

12.1.5 Хүний эрүүл мэндэд харшил үүсгэдэггүй ногоон мод, бутыг сонгон, барилгаас 6-10 метрийн зайд, 2 цонхны хоорондох хананы тушаа, өндөр ургасан үедээ цонхонд бүдэг сүүдэрлэлт үүсгэх, харшлын бодис саармагжих орчинд тарина.

12.1.6 Орчны талбайн гэрэлтүүлэг бүрэн, хангалттай, галын аюулаас сэргийлсэн бүрхүүлтэй байна.

12.1.7 Гадна талбайд зонхилох салхины доод зүгт, талбайн сандлаас 1,5-2 метрийнзайд, 30 метр тутамд хогийн сав байхаар төлөвлөж, байрлуулна.

12.1.8 Гадна талбайд нийтийн биеийн тамирын талбайг тохижуулсан байна.

12.1.7 Төвд үйлчлүүлэхээр ирсэн хүмүүсийн морины уяа, автомашины зогсоол, бие засах газрыг зонхилох салхины доод талд байрлуулна.

12.1.8 Гадна орчны тохижилт, барилга, байгууламж, өрөө, тасалгаа нь хөдөлмөр, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, цэвэр үзэмжтэй, тохитой байна.

12.1.9 Гадна орчинд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэдэд ээлтэй бариул, налуу зам, амрах сандал зэргийг зөв төлөвлөн зохион байгуулсан, жил бүр тохижилт хийгдсэн байна.

12.1.10 Шинээр баригдах сумын Эрүүл мэндийн төвийн барилгад сумын эмчийн орон сууцыг барьсан байна.

12.2 Барилга байгууламжийн эрүүл ахуйн шаардлага

12.2.1 Барилга нь 8-10 баллын газар хөдлөлтөнд тэсвэртэй, аянга зайлуулагч газардуулгатай байна.

12.2.2 Барилгын цонх, хаалга нь угаалга цэвэрлэгээний шаардлага хангасан цайвар өнгөтэй, битүүмжлэл сайтай, бүрэн ажиллагаатай, түгжээтэй, цонх нь зориулалтын хаалт, сүүдэрлэлттэй, хаалга нь гадагшаа онгойдог байна.

12.2.3 Байгууллагын гадна болон дотор талын шал нь халтиргаа, гулгаа үүсгэхгүй эрүүл ахуйн, аюулгүй байдлын шаардлага хангасан, угааж цэвэрлэхэд хялбар, өнгө үзэмжтэй байна.

12.2.4 Эмчилгээ, үйлчилгээний өрөө нь 18-20 хэмээс доошгүй дулаантай, агаарын солилцоо тогтмол хийх нөхцлийг бүрдүүлсэн байна.

12.2.5 Эмнэлгийн барилга нь цэвэр, бохир усны системд холбогдсон, стандартын шаардлага хангасан ариутгах татуургын байгууламжтай байна.

12.2.6 Эмчилгээ, үйлчилгээний өрөө, тасалгаанд эрүүл ахуй, халдвар хамгааллын шаардлага хангасан угаалтууртай (гараар нээж, хаахгүй, мэдрэгчтэй) байна.

12.2.7 Эмчлүүлэгчийн усанд орох нөхцлийг бүрдүүлсэн байна.

12.2.8 Хүнд өвчтөн, тэргэнцэртэй иргэд орох, гаргах нөхцлийг хангасан байна.

12.2.9 Барилгын урсгал засвар, цэвэрлэгээ, эцсийн халдваргүйтгэлийг жилд 1 удаа тогтмол хийнэ.

12.2.10 Барилга байгууламжийн байршил, гал болон аюулгүй ажиллагааны урсгал хөдөлгөөнийг харуулсан тойм зургийг нийтэд харагдахуйц газар байрлуулсан байна.

12.2.11 Ариун цэврийн өрөөнд нян устгах шингэн саван, спиртэн суурьтай халдваргүйжүүлэх бодис, угаалтуур (гараар нээж, хаадаггүй мэдрэгчтэй) байршуулна.

12.2.12 Төрөх, мэс засал, лаборатори, угаалга, агуулах, цогцос хадгалах зэрэг өрөө нь хэвийн ажиллагаатай салхивч болон эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан агааржуулалтын системтэй байна.

12.2.13 Өрөө, тасалгаа нь эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан угааж цэвэрлэхэд хялбар, өнгө үзэмжтэй байна.

12.2.14 Эмгэг судлалын хэсэг нь тусдаа байрлалтай, нэвт харагдахгүй цонхтой, хэвийн ажиллагаатай салхивч болон агааржуулалтын системтэй, зориулалтын дагуу тоноглогдсон байна.

12.2.15 Хуурай хүнсний агуулах нь агааржуулалт, гэрэлтүүлэг сайтай, хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, таславч бүхий тавиуртай байна.(хуурай хүнсний, эд аж ахуйн гэх мэт)

12.2.16 Шинээр баригдах барилга, байгууламжийн зураг төслийг эрүүл мэндийн байгууллагын орчны стандарт, барилгын дүрэм, барилгын эрүүл ахуйн шаардлага, бусад стандарт, зааврын дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага төлөвлөн хэрэгжүүлнэ.

12.3 Гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн эрүүл ахуйн шаардлага

12.3.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь цахилгааны нэмэлт нөөц үүсгүүртэй байна.

12.3.2 Өрөө, хонгил нь байгалийн болон ердийн гэрэлтүүлгээр хангагдсан байх ба халалт багатай, эрүүл ахуйн шаардлага хангасан сүүн гэрэлтүүлэг (флуорисценцийн ламп) ашиглана.

12.3.3 Эмчлүүлэгчийн өрөө нь 60 люкс, үзлэгийн өрөө 100 люкс бүхий сүүн (флуорисценцийн ламп) гэрэлтүүлэгтэй, хэвтүүлэн эмчлэх тасагт ханын болон зөөврийн гэрэлтүүлэг, ханын залгууртай байна.

12.3.4 Төрөх, мэс заслын өрөө 1500-3000 люкс, мэс ажилбарын талбай 3000-6000 люкс, эмчлүүлэгчийн өрөө 60 люкс, үзлэгийн өрөө 100 люкс бүхий хэт халалтаас сэргийлсэн өдрийн буюу флуорисценци гэрэлтүүлэгтэй байна.

12.3.5 Цогцос хадгалах өрөөний болон үдэх ёслолын өрөөний гэрэлтүүлэг нь ханын 30-40 ваттын гэрэлтүүлэгтэй, эмнэлгээс эмгэг судлалын хэсэг рүү хүрэх зам гэрэлтүүлэгтэй байна.

12.4 Гал тогоо, хоол хүнсний хангамжийн эрүүл ахуйн шаардлага

12.4.1 Гал тогооны хэсэг нь хүнсийг хүлээн авч цэвэрлэх, бэлтгэх, халуун ажиллагааны хэсэг, түгээх хэсэг гэсэн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан зөв урсгал, зохион байгуулалтай байна.

12.4.2 Гал тогооны нэгж нь эмчлүүлэгчдэд эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан хоолоор үйлчилж, хоолны газрын ариун цэврийн дүрмийг баримтлан ажиллана.

12.4.3 Гал тогооны өрөөний хана, шал, тааз нь угааж цэвэрлэхэд хялбар, агааржуулалтын системийг байрлуулсан ердийн салхивчтай байна.

12.4.4 Гал тогооны хэсэгт гэрэлтүүлэг, агаарын солилцоо хийгдэх боломж бүрдсэн хүнсний төрөлжсөн (түүхий бүтээгдэхүүн, хуурай хүнсний) агуулахтай байна.

12.4.5 Гал тогоонд ундны усны стандартын шаардлага хангасан ус хэрэглэнэ.

12.5 Ажлын байрны эрүүл ахуйн шаардлага

12.5.1 Ажиллагсад зориулсан зориулалтын тавилга хэрэгслээр хангагдсан амрах өрөөтэй байна.

12.5.2 Ажиллагсдыг тухайн ажил мэргэжлийн онцлогт тохирсон аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, 2-оос доошгүй ээлжийн ажлын хувцсаар хангах ба зохих журмын дагуу шинэчилнэ.

12.5.3 Техникийн болон гүйцэтгэгч ажилтныг ажлын зориулалтын хувцас, хэрэглэлээр бүрэн хангах ба ажилтан тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хамгаалах хэрэгслийг зохих журмын дагуу өмсөнө.

12.6 Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орчны эрүүл ахуйн шаардлага

12.6.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд батлагдсан стандартын дагуу ээлтэй орчин бүрдүүлж ажиллана.

12.6.2 Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэдэд зориулагдсан тусгай зориулалтын ариун цэврийн өрөө, налуу зам, хана дагасан бариул, тэргэнцэртэй байна.

12.7 Усны чанар, аюулгүй байдал

12.7.1 Эрүүл мэндийн байгууллагад хэрэглэгдэх унд ахуйн ус нь стандартын шаардлага хангасан байна.

12.7.2 Ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, бүсийн дэглэмийг мөрдөж ажиллана.

12.8 Эрүүл ахуйн нөхцөл, халдвараас сэргийлэх үйл ажиллагааны нийтлэг шаардлага

12.8.1 Халдвараас сэргийлэх үйл ажиллагааг чанарын алба удирдлагаар хангаж ажиллана.

12.8.2 Чанарын алба нь халдвараас сэргийлэх мөрдөгдөж буй тушаал, заавар, журмын хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангуулна.

12.8.3 Эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгаалал, хяналтын тогтолцоонд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тушаал, зааврыг мөрдөж ажиллана.

12.8.4 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, ариутгал, халдваргүйтгэлийн сургалтанд ажиллагсдыг бүрэн хамруулж, мэдлэг олгож, мэргэшүүлсэн байна.

12.8.5 Эрүүл мэндийн ажиллагсад нь эмнэлгийн гадаад болон дотоод халдвараас сэргийлэх зохих дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллана.

12.8.6 Тусламж, үйлчилгээний нэг удаагийн зориулалтын хэрэгсэлтэй, хүрэлцэхүйц хэмжээний нөөцтэй байна.

12.8.7 Жил бүр ажиллагсдыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулна.

12.8.8 Цэвэрлэгээ, халдваргүйтгэл, шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батласантушаал журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

12.8.9 Халдвараас урьдчилан сэргийлэх болон голомтын халдваргүйтгэл хийх багаж хэрэгсэл, халдваргүйтгэх бодисоор тасралтгүй хангана.

12.8.10 Халдварт өвчнөөс хамгаалах бүрэн өмсгөл, хэрэгсэл гурваас доошгүй иж бүрдлийг бэлэн байдалд байлгана.

12.9 Аюулгүй байдлыг хангах

12.9.1 Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдал

12.9.1.1 Чанарын алба нь үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

12.9.1.2 Эмч, мэргэжилтэн нь тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, эрсдлээс сэргийлэх үйл ажиллагааг чанд мөрдөж ажиллана.

12.9.1.3 Үйлчлүүлэгч, түүний гэр бүлийнхэнд эмчилгээ, үйлчилгээний талаар тодорхой мэдээллийг өгч, аюулгүй байдалдаа хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.

12.9.2 Ажиллагсдын аюулгүй байдал

12.9.2.1 Чанарын алба нь ажиллагсдын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

12.9.2.2 Эрүүл мэндийн ажиллагсдыг урьдчилан сэргийлэх үзлэг болон сүрьеэ, вируст гепатит В, С илрүүлэх шинжилгээнд хамруулан, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг авна.

12.9.2.3 Эмч, мэргэжилтэнг гепатит В вирусийн эсрэг дархлаажуулалтанд заавал хамруулна.

12.9.2.4 Ажиллагсдыг шаардлагатай үед Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөсөн томуугийн шинэ вирусийн халдвар, улаанууд, гэдэсний балнад, тарваган тахлаас сэргийлэн вакцинд зохих хууль, шийдвэрийн дагуу хамруулна.

12.9.2.5 Мэргэжлээс шалтгаалсан осол, гэмтэл, өртөлт /хурц үзүүртэй зүйлд хатгагдах, цус цусан бүтээгдэхүүн арьс салстад үсрэх/, өвчлөлийг илрүүлж, удирдлагад мэдээлэн, арга хэмжээ авна.

12.9.2.6 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны сургалтыг нийт ажилчдад жил бүр, шинээр ажилд орж байгаа ажилтанд тухай бүр зохион байгуулж, мэдлэг, дадал, ур чадварыг эзэмшүүлэн, баталгаажуулна.

12.9.3 Эмнэлгийн багаж, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал

12.9.3.1 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах болон техникийн аюулгүй ажиллагааны заавар журмуудыг мөрдөнө.

12.9.3.2 Тоног төхөөрөмжийн газардуулгын нэгдсэн системтэй, шаардлагатай цахилгаан тоног төхөөрөмжүүдийг газардуулгад зөв холбох үйл ажиллагааг мэргэжлийн хүмүүсээр гүйцэтгүүлэхийг удирдлага хариуцна.

12.9.3.3 Техник, тоног төхөөрөмжийн холболт, монтажийг олон улсын стандартад нийцсэн, чанарын шаардлага хангасан, сайн чанарын цахилгааны утсаар хийсэн байна.

12.10 Галын аюулгүй байдал

Галын аюулын үед “Галын аюулгүй байдал техникийн шаардлага” стандартын дагуу ажиллана.

Галын болзошгүй ослын үед цахилгаан болон чанга дуугардаг ердийн хонх, чанга яригч зэрэг дохиоллын энгийн системийг ашиглах нөхцлөөр хангагдсан байна.

ТӨГСӨВ.

Стандартын Үзлэг-2018

А хавсралт

(норматив)

Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн
хүний нөөцийн доод хязгаар

№	Орон тоо	Эмнэлгийн мэргэжилтний тоо						
		1 дүгээр зэрэглэл	2 дугаар зэрэглэл	3 дугаар зэрэглэл	Сум дундын эмнэлэг			
1.	Дарга	1			1			
2.	Нягтлан бодогч	1			1			
3.	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан (олон нийттэй харилцах ажилтан)	1			1			
4.	Ерөнхий мэргэжлийн эмч	1200 хүн амд 1 их эмч	1000 хүн амд 1 их эмч					
5.	Дотрын мэргэжлийн эмч				1			
6.	Эх барих эмэгтэйчүүдийн эмч	Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь зэрэглэл, хүн амын тоо, тусламж үйлчилгээний нэр төрөл, өвчлөл, хэрэгцээнд үндэслэн өрх, уламжлалт, хүүхэд, мэс засал, эх барих эмэгтэйчүүд, эрүү нүүрний, мэдээгүйжүүлэг-эрчимт эмчилгээний, лабораторийн сэргээн заслын... гэх мэт мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнг ажиллуулна.			1			
7.	Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний эмч				1			
8.	Мэс засалч эмч				1			
9.	Хүүхдийн эмч				1			
10.	Уламжлалын эмч				1			
11.	Шүдний эмч				1			
12.	Мэдээгүйжүүлгийн сувилагч				1			
13.	Лабораторийн эмч				1			
14.	Халдвар судлаач							хавсран
15.	Эх баригч				1	1	2-4	2-4
16.	Ахлах сувилагч	1 эсвэл хавсарч	1	1	1			
17.	Сувилагч	1 эмчид 2-3 сувилагч			1 эмчид 3 сувилагч			
18.	Нийгмийн эрүүл мэндийн сувилагч	1						
19.	Багийн бага эмч /сувилагч/	Багийн тоогоор (Алслагдсан байдлаас хамааран шаардлагаар нэмэлтээр)						
20.	Рентген техникч	Тусламж үйлчилгээний багцын дагуу шаардлагаар			1			
21.	Эм найруулагч	Зэрэглэлээс хамаарч шаардлагаар			1			
22.	Лаборант	1			1-2			
23.	Эрүүл мэндийн статистикч (мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)	1			1			
24.	Ариутгагч /автоклавчин	1			1-2			
25.	Жолооч	1	1	1-2	2			
26.	Нярав	1 эсвэл хавсарч			1			
27.	Тогооч	1			1			
28.	Бэлтгэгч	-	-	1	1			
29.	Үйлчлэгч	1	1-2	3-4	3-4			
30.	Биеийн тамир – чийрэгжүүлэлтийн арга зүйч, галч, угаагч	Шаардлагаар						
31.	Сумын хүн амын тоо цөөхөн, стандартаар 1 их эмч ногдох тохиолдолд ээлжийн сувилагч 4 байхаар тооцно. Энд дурьдагдаагүй бусад мэргэжлийн шаардлагатай орон тоог тухайн эмнэлгийн онцлогоос шалтгаалж нэмэгдүүлэн ажиллуулж болно. Эмнэлгийн аж ахуйн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлсэн тохиолдолд тухайн ажил үйлчилгээг эрхэлж буй орон тоог хасаж тооцно.							

В хавсралт

(норматив)

Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн барилгын өрөө, тасалгааны талбай

Өрөөний зориулалт	Багийн эмч	Өрөөний талбай	Тавих шаардлага, эд хогшил
Үүдний буюу хүлээлгийн хэсэг	10-15 м ²	10-15 м ²	Өвчтөний хүлээлгийн өрөө – сандал, өвчтөнд зориулсан мэдээлэлтэй
Бүртгэлийн хэсэг			Бүртгэлийн ширээ, өвчний түүх хадгалах шүүгээ, утас, компьютер
Эмчийн үзлэгийн өрөө	15 м ²	18 м ²	Үзлэгийн ор, ширээ, сандал, компьютер, хэвлэгч, номын шүүгээ
Тарианы өрөө	18 м ²	18 м ²	Эмийн шүүгээ, хөргөгч, сувилагчийн тэргэнцэр, эмчилгээний ор, отсос, мэдрэгчтэй угаалтуур
Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний өрөө	18 м ²	18 м ²	Эмийн шүүгээ, хөргөгч, үзлэгийн ор, тэргэнцэр, яаралтай тусламжийн иж бүрдлийн шүүгээ, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, отсос, өвчтөний хяналтын монитор
Тусгаарлах өрөө	18 м ²	18 м ²	Тусгаарлах өрөө нь дотроо ариун цэврийн өрөөтэй, гадагш шууд гарах хаалгатай байна. Ор, шүүгээ, сандал, мэдрэгчтэй угаалтууртай
Сэргээн засах эмчилгээний өрөө	-	18 м ²	Сэргээн засах эмчилгээний удирдамж, стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж (С хавсралт)
Физик эмчилгээний өрөө	-	18 м ²	
Дархлаажуулалтын өрөө	-	15 м ²	Вакцины хөргөгч, тог баригч, эмийн шүүгээ, вакцин зөөх сав, тэргэнцэр, өлгий вандан
Хэвтүүлэн эмчлэх өрөө	-	1 оронд 7-9 м ²	Ор, шүүгээ, сандал ор тус бүрт 1 ширхэг
Эхийн амрах байр	-	1 оронд 7-9 м ²	Ор, шүүгээ, сандал, ширээ
Эх баригчийн өрөө	-	18 м ²	“Амаржих газрын бүтэц, үйл ажиллагаа” MNS 6881:2010 стандартын дагуу
Төрөх өрөө	-		
Эм хадгалах өрөө	-		
Эмийн сангийн өрөө	-		
Лабораторийн өрөө	-	18 м ²	Цус авах болон шинжилгээний өрөөнд зориулсан сандал, ширээ, лабораторийн зориулалттай ширээ, хөргөгч, тог баригч, С хавсралтад заасан тоног төхөөрөмж
Рентгены өрөө (зөөврийн бага оврын)	-	Өрөөний хана, шал, тааз, хаалга, цонх нь туяанаас хамгаалагдсан тусгай зориулалтын байна.	
Цогцос хадгалах өрөө	-	Үдэх ёслол хийхэд зориулагдан тохижуулсан, нэвт харагддаггүй цонхтой, хөргүүрийн, агааржуулалтын нөхцлийг хангасан байна.	
Ариун цэврийн өрөө	1 суултуур, 1 угаалтуурт 2,7 м ²		Ажиллагсад болон өвчтөнүүдэд зориулсан халуун устай шүршүүртэй байна.
Архивын өрөө	-	Материал хадгалах сав, өвчний түүх хадгалах тавцан шүүгээ, чийг халуун хэмжигч, чийгшүүлэгч төхөөрөг, галын хор	
Сургалтын өрөө (номын сан)	-	Сургалт явуулах нөхцлөөр хангагдсан компьютер, хувилагч машин, самбар зэргээр хангагдсан байна.	

Албан хэрэгцээнд олгов.

Стандарт, хэмжилтийн газар.

Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын үндэсний төв. 2018-06-20

Угаалгын буюу цэвэрлэгээний нэгдсэн өрөө	-	Өөрийн халуун хүйтэн усны хангамжтай, багаж ангилах, хадгалах тавцан, автоклав нь цэвэр, бохир усанд холбогдсон, газар доогуур явсан цахилгааны эх үүсвэрт холбогдсон, ариутгах зүйлсийн ариутгалд бэлтгэх, савлах, ариутгасны дараа гаргаж, задлахад хангалттай зайтай газарт байрлуулна.
Гал тогооны өрөө (бэлтгэх, хадгалах, хооллох)	-	Хана, шал, таазыг угааж цэвэрлэхэд хялбар материалаар хийж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж, агааржуулалтын систем, халуун уурын системтэй байна. Хаягдал гаргах өрөө нь гадагш хаалгатай байна.
Агуулахын өрөө	-	Чийг халуун хэмжигч, чийгшүүлэгч төхөөрөг, галын хор
Машины гараж	-	Сэлбэгийн тавцан, шүүгээ, галын хор

Стандартын үзлэг-2018

С хавсралт
(норматив)

**Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн багаж хэрэгсэл,
тоног төхөөрөмж**

№	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн нэр	Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тоо			
		(доод хязгаар, ширхэгээр)			
		I зэрэглэл	II зэрэглэл	III зэрэглэл	сум дундын эмнэлэг
Багаж, хэрэгсэл					
С1. Эмч, бага эмч, сувилагчийн иж бүрдэл багаж, хэрэгсэл					
1	Чагнуур	Эмчийн тоогоор			
2	Даралтын аппарат	Эмчийн тоогоор			
3	Хараа шалгах хүснэгт	1	1	1	2
4	Хэл дарагч, төмөр, ариутгах боломжтой	2	2	2	3
5	Хэл дарагч нэг удаагийн	1 сарын нөөцтэй байна.			
6	Мэдрэлийн алх	Эмчийн тоогоор			
7	Үзлэгийн духны толь	1	1	1	1
8	Хоолойн үзлэгийн иж бүрдэл толь	1	1	1	1
9	Ларингоскоп (иж бүрдлээр)	1	1	1	1
10	Отоскоп иж бүрдэл	1	1	1	1
11	Офтальмоскоп иж бүрдэл	1	1	1	1
12	Аарцаг хэмжигч	1	1	1	1
13	Чихний үзлэгийн иж бүрдэл толь	1	1	1	1
14	Хамрын үзлэгийн иж бүрдэл (нярай болон хүүхдийн)	1	1	1	1
15	Хамрын үзлэгийн иж бүрдэл (том хүний)	1	1	1	1
16	Нярайн сорох хэрэгсэл	1	1	1	1
17	Чихний цэвэрлэгээ хийх хэрэгсэл	1	1	1	1
18	Чангалуур, резинэн	1	1	3	
19	Халууны шил	3	3	3	
20	Жирэмсний хугацаа тодорхойлогч хүрд	1	1	2	2
21	Ургийн чагнуур	1	1	2	2
22	Туузан метр	2	2	3	3
23	Хямсаа, хүүхдийн	1	1	1	1
24	Хайч	1	1	1	1
25	Шээсний хурдавчилсан туузан оношлуур	Нэг сарын нөөцтэй байна			
26	Жирэмсний хурдавчилсан туузан оношлуур	Нэг сарын нөөцтэй байна			
27	Гемоглобины хурдавчилсан туузан оношлуур	Нэг сарын нөөцтэй байна			
28	Резинен бээлий	Нэг сарын нөөцтэй байна			
29	Халуун хүйтэн жин	5	5	5	5
30	Шээлгүүрхэмжээ тус бүрээр	Нэг сарын нөөцтэй байна			
31	Судасны уян зүү	Нэг сарын нөөцтэй байна			
32	Төвийн хураагуур судасны гуурс (Сельдингер)	Нэг сарын нөөцтэй байна			
33	Бургуй тавих хэрэгсэл хошууны хамт (нэг удаагийн)	Нэг сарын нөөцтэй байна			

34	Нугасны шингэн авах зүү (нэг удаагийн)	Нэг сарын нөөцтэй байна			
35	Хаймсуур	Нэг сарын нөөцтэй байна			
36	Хөтөвч (эр, эм)	2	2	4	4
37	Анус үзлэгийн толь (нэг удаагийн)	Нэг сарын нөөцтэй байна			
38	Хумсны хайч	2	2	2	2
39	Вакцин хадгалах зориулалтын хөргөгч (термометртэй)	1	1	1	1
40	Тог тохируулагч, баригч	1	1	2	2
41	Дархлаажуулалтын өрөөний термометр	1	1	1	1
42	Дархлаажуулалт хийх зориулалтын зүү тариур	Нэг сарын нөөцтэй байна			
43	ХДХВ/ДОХ илрүүлэх оношлуур	Нэг сарын нөөцтэй байна			
44	В,С гепатит илрүүлэх оношлуур	Нэг сарын нөөцтэй байна			
45	Тэмбүү илрүүлэх оношлуур	Нэг сарын нөөцтэй байна			
46	Зоонозын өвчнийг илрүүлэх оношлуурууд	Нэг сарын нөөцтэй байна			
С2. Яаралтай тусламжийн иж бүрдэл багаж, хэрэгсэл					
1	Бөөрөн таваг	1	1	3	3
2	Багаж, хэрэгсэл хадгалах таглаатай босоо төмөр сав	2	2	2	2-3
3	Багаж хийх хэвтээ төмөр сав	1	1	1	2
4	Бээлий, (ариутгаагүй)	Нэг сарын нөөцтэй байна			
5	Мэс заслын бээлий (ариутгасан)	Нэг сарын нөөцтэй байна			
6	Шээлгүүр (нэг удаагийн) хэмжээ тус бүрээс	Нэг сарын нөөцтэй байна			
7	Халуун, хүйтэн жин тавигч (резинен)	1	3	3	3
8	Ходоод угаах гуурс (нэг удаагийн)	Нэг сарын нөөцтэй байна			
9	5 мм х 122 см урттай 12 хуруу гэдэс угаах гуурс (полиэтилэн, нэг удаагийн)	Нэг сарын нөөцтэй байна			
10	Нярайн хамраар хооллох гуурс (хэмжээ 380 мм х 2,64мм)	Нэг сарын нөөцтэй байна			
11	Мэс заслын наалдамхай пластер, (25 мм х 10 м)	Нэг сарын нөөцтэй байна			
12	Сунамтгай ороох боох материал, наалдахгүй, хэмжээ 75 мм х 5 м	Нэг сарын нөөцтэй байна			
13	Ариутгаагүй бинт	Нэг сарын нөөцтэй байна			
14	Мэс заслын гар угаах сойз	Нэг сарын нөөцтэй байна			
15	Хөвөн, ариутгаагүй	Нэг сарын нөөцтэй байна			
16	Эм хадгалах полиэтилен уут	Нэг сарын нөөцтэй байна			
17	Ариутгаагүй дөрвөлжин хэлбэрийн зөөлөн хөвөн-бинт	Нэг сарын нөөцтэй байна			
18	Ариутгалын чанарыг шалгах туузан тест	Нэг сарын нөөцтэй байна			
19	Нэг удаагийн зүү, тариур	Нэг сарын нөөцтэй байна			
С3. Мэс заслын иж бүрдэл багаж, хэрэгсэл					
1	Багаж ариутгагч сав (стерилизатор)	5	5	5	5
2	Бикс жижиг	5	5	5	5
3	Бикс том	1	2	5	5
4	Бөөрөн таваг	5	5	10	10

5	Мэс ажилбарын багажны иж бүрдэл (хэвлийн хөндийн)	-	-	3	3
6	Спиртен дэн	1	1	2	2
7	Силкен утас хэмжээтүс бүрээс	Нэг сарын нөөцтэй байна			
8	Хямсаа, Мичел төрлийн, 120 мм, 150 мм хэмжээтэй	1	1	2	2
9	Хямсаа, Келли төрлийн, цус тогтоох зориулалттай, шулуун, 140 мм хэмжээ	1	1	2	2
10	Хямсаа, Кохер төрлийн, түгжээтэй, цус тогтоох зориулалт бүхий, 140мм хэмжээ,	1	1	2	2
11	Хямсаа, хөвөн төрлийн материал баригч, шулуун, 200 мм хэмжээ,	1	1	2	2
12	Зүү баригч, шулуун, 160 мм,	1	1	2	2
13	Жижиг мэс ажилбарын скальпель хэмжээ тус бүрээр	Нэг сарын нөөцтэй байна			
14	Мэс заслын зүү (нэг удаагийн)	Нэг сарын нөөцтэй байна			
15	Ерөнхий мэс заслын хутга, уян, гогцоотой	1	1	2	2
16	Чихний хямсаа, үзүүр нь бөөрөнхий буюу зууван хэлбэртэй	1	1	2	2
17	Мэс заслын шулуун хайч, урт нь 145 мм	1	1	2	2
18	Мэс заслын шулуун хайч, хүүхдийн, урт нь 120 мм	1	1	2	2
C4. Эх, хүүхдийн иж бүрдэл багаж, хэрэгсэл					
1	Аарцаг хэмжигч	1	1	1	1
2	Үзлэгийн ор	1	1	1	1
3	Төрөх ор	1	1	1	2
4	Үр хөндөх багажны иж бүрдэл	1	1	1	2
5	Ерөндөг тавих, авах багажны иж бүрдэл	1	1	2	2
6	Вакуум соруул хошууны хамт	1	1	2	2
7	Эх барих багажны иж бүрдэл	1	1	2	2
8	Дуслын автомат шахуурга	1	1	2	2
9	Бөөрөн хэлбэрийн таваг	1	1	1	1
10	Шингэн хийх зориулалтын сав, 6 литр багтаамжтай	1	1	1	
11	Хэмжүүртэй ба бариултай сав, 500 мл	1	1	1	1
12	Шээлгүүр, нэг удаагийн	Нэг сарын нөөцтэй байна			
13	Эмэгтэйчүүдийн үзлэгийн толь	Нэг сарын нөөцтэй байна			
14	Умайн зонд, 300 мм урттай, 20 мм-н алхамтай хэмжээстэй	1	2	3	3
15	Эх барихын мэс заслын иж бүрдэл	-	-	1	2
C5. Эмнэлгийн оношлогооны тоног төхөөрөмж					
1	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	1	1	1	1
2	Хэт авианы аппарат	1	1	1	1
3	Рентген аппарат (дигитал)	-	-	1	1
C6. Лабораторийн тоног төхөөрөмж					
1	Биохимийн анализатор		1	1	1

	(нээлттэй системтэй)				
2	Шээсний анализатор	1	1	1	1
3	Гематологийн анализатор	1	1	1	1
4	Коагулограммын анализатор	-	1	1	1
5	Центрифуг	1	1	1	1
6	Микроскоп	1	1	1	1
7	Ус нэрэгч	1	1	1	1
8	Автоклав (жижиг)	1	1	1	1
9	Термостат	1	1	1	1
10	Лабораторийн хөргөгч	1	1	1	1
11	Электрон жин	1	1	1	1
12	Эс тоологч	1	1	2	2
13	Лабораторийн зориулалтын ширээ сандал	1	1	1	1
14	Өндөг цоологч (нэг удаагийн)	Нэг сарын нөөцтэй байна			
15	Шээсний туузан-оношлуур уншигч иж бүрдэл	Нэг сарын нөөцтэй байна			
16	Гемоглобин тодорхойлогч иж бүрдэл	Нэг сарын нөөцтэй байна			
17	Глюкозаметр (сахар тодорхойлогч)	Нэг сарын нөөцтэй байна			
18	Креатинин фосфокиназа, КФК Тропонин илрүүлэх зүрхний түргэн оношлуур	Нэг сарын нөөцтэй байна			
19	Цус цуглуулах хүүдий	2-4 ширхэг		4-5	
20	Цусны АВО, резус, бүлэг, хувийн тохироо тодорхойлох урвалж, оношлуур	Нэг сарын нөөцтэй байна			
21	Кумбсын урвалж	Нэг сарын нөөцтэй байна			
22	СОЭ хэмжигч пипетка	2			
23	Цусны бүлэг тодорхойлох таваг	1-2		2	
24	Хуруу шил зүүний хамт (вакуум)	Нэг сарын нөөцтэй байна			
25	Хуруу шилний тавиур	Нэг сарын нөөцтэй байна			
26	Автомат пипетик 10-100 мкл	3		5	
27	Цус сэлбэх зориулалтын шүүлтүүртэй систем	Нэг сарын нөөцтэй байна			
С7. Мэс заслын тоног төхөөрөмж					
1	Амьсгалын аппарат	-	-	1	1
2	Өвчтөний монитор	-	1	1	1
3	Пульсоксиметр	1	2	3	3
4	Сорох төхөөрөмж (Отсос)	1	1	2	2
5	Коагуляцийн аппарат	-	1	1	1
6	Мэс заслын хажуугийн гэрэл	1	1	1	1
7	Мэс заслын ор	-	-	1	1
8	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	1	1	2	2
9	Дефибрилятор	1	1	1	1
С8. Эх барих, эмэгтэйчүүдийн тоног төхөөрөмж					
1	Төрөх ор	1	1	1	1
2	Ургийн бичлэгийн аппарат	-	-	1	1
3	Нярайн жин хэмжигч	1	1	1	1
4	Нярайн өндөр хэмжигч	1	1	1	1
5	Сорох төхөөрөмж (Нярай)	1	1	1	1
6	Ларингоскопи	1	2	2	2
7	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат	1	1	2	2

8	Инкубатор	-	1	1	1
9	Дулаацуулагч	1	2	2	2
10	Фото эмчилгээний аппарат	-	1	1	1
11	Тариурын автомат шахуурга	1	1	1	1
12	Хяналтын монитор (5 үзүүлэлттэй)	1	1	2	2
13	Нярайн пульсоксиметр	1	1	2	2
С9. Шүдний тоног төхөөрөмж					
1	Зөөврийн хурдан эргэлттэй өрөмдөгч машин	-	-	1	1
2	Өвчтөний сандал	-	-	1	1
3	Эмчийн болон сувилагчийн сандал	-	-	2	2
4	Хийн компрессор	-	-	1	1
5	Шүдний зонд	-	-	18	18
6	Шүдний толь	-	-	18	18
7	Шүдний хямсаа	-	-	18	18
8	Экскватор	-	-	18	18
9	Гладилка	-	-	18	18
10	Штопфер	-	-	18	18
11	Шүдний бахь	-	-	18	18
12	Муруй хоёр талт элеватор	-	-	18	18
13	Шулуун элеватор	-	-	18	18
14	Бөөрөн таваг	-	-	2	2
15	Хэл дарагч	-	-	18	18
16	Багажийн шүүгээ	-	-	1	1
17	Эмийн тэргэнцэр	-	-	1	1
18	Автоклав (жигж)	-	-	1	1
19	Кварцын гэрэл	-	-	2	2
20	Сувгийн урт хэмжигч аппарат	-	-	1	1
21	Хуванцар ломбо шарах аппарат	-	-	1	1
22	Бор машин	-	-	1	1
23	Сувгийн багаж	-	-	2	2
24	Эмийн шилэн хундага	-	-	3	3
25	Тариур (зориулалтын төмөр)	-	-	2	2
26	Эм зуурах шпатель	-	-	2	2
27	Мэс заслын хутга	-	-	5	5
С10. Сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмж					
1	Хэт өндөр давтамжийн аппарат	-	1	2	2
2	Соллюкс	1	1	2	2
3	Хэт ягаан туяаны аппарат	-	1	1	1
4	Тренажер/Дасгалын аппарат	-	1	1	1
5	Утлагын аппарат (нярай, хүүхэд, том хүний масктай)	1	2	3	3
6	Поток	-	1	1	1
7	Татлагын ор	-	-	1	1
С11. Уламжлалт эмчилгээний тоног төхөөрөмж					
1	Зүүний цахилгаан аппарат	1	1	1	1
2	Бумба	10	20	20	20
3	Төөнүүр	Нэг сарын нөөцтэй байна			
4	Хануурын хутга (нэг удаагийн)	Нэг сарын нөөцтэй байна			
5	Шивүүрийн алх	1	1	1	1
6	Массажны ор	1	1	1	1
7	Кушетка	1	1	1	1
С12. Ариутгалын тоног төхөөрөмж					

1	Автоклав	1	1	1	1
2	Ариутгалын гэрэл суурин	2	3	5	5
3	Ариутгалын гэрэл зөөврийн	1	1	2	2
4	Автомакс	1	2	2	2
С13. Угаалгын тоног төхөөрөмж					
1	Угаалгын машин (10кг-аас доошгүй)	1	1	2	2
2	Жирийн индүү, уурын индүү	1	1	2	2
3	Хатаагч	1	1	1	1
С14. Гал тогооны тоног төхөөрөмж					
1	1-р хоолны тогоо	1	1	1	1
2	2-р хоолны тогоо	1	1	1	1
3	Цахилгаан пийшин	1	1	1	1
4	Шарах шүүгээ	1	1	1	1
5	Хөргөгч	1	1	1	1
6	Хөлдөөгч	1	1	1	1
7	Ус буцалгагч	1	1	1	1
С15. Сургалтын тоног төхөөрөмж					
1	Компьютер иж бүрдэл	1	1	2	2
2	Хэвлэгч	1	1	1	1
3	Проектор	1	1	1	1
4	Хувилагч	1	1	1	1
5	Компьютерийн тог баригч (1 цагаас багагүй барих)	1	1	1	1
6	Проекторын дэлгэц	1	1	1	1
7	Дижитал зургийн аппарат, 1ш	1	1	1	1
8	Сургалт, сурталчилгаанд ашиглах телевизор	1	1	1	1
9	Сургалт, сурталчилгаанд ашиглах дүрстэй мэдээлэл, самбар, биет үзүүлэн	1	1	1	1
С16. Эмнэлгийн бус тоног төхөөрөмж					
1	Эмнэлгийн хог хаягдлыг шатаах зуух	1	1	1	1
2	Цахилгаан үүсгүүр /мотор/	1	1	1	1
3	Аваарийн гэрэл	1	1	1	1
4	Цогцос хадгалах хөргөгч	1	1	1	1
С17. Бусад					
1	Өвчтөн зөөх дамнуурга	2	2	2	3
2	Үзлэгийн ор	Тасаг, нэгжийн тоогоор			
3	Дуслын штатив	3	3	5	5
4	Сувилагчийн ширээ	1	1	2	2
5	Багажны ширээ	1	1	1	1
6	Өвчтний тэргэнцэр	1	1	2	2
7	3 секцтэй үзлэгийн ор	1	1	1	1
8	Багажны тэргэнцэр	1	1	1	1
9	Өндөр хэмжигчтэй электрон жин	1	1	1	1
10	Хөргөгч	1	1	1	1
11	Вакцин зөөх сав	1	2	2	2
12	Вакцины хөргөгч	1	1	1	1
13	Үзлэгийн гэрэл, босоо	1	1	1	1
14	Эмийн шүүгээ	1	1	1	1
15	Багажийн шүүгээ	1	1	1	1
16	Ажилтны хувцасны шүүгээ	Ажиллагсдын тоогоор			

Албан хэрэгцээнд өггөв.

Стандарт хэмжил зүйн газар.

С18. Эмийн сангийн тоног төхөөрөмж (Эмийн санд тавигдах нийтлэг шаардлагыг мөрдөнө.)					
С19. Дэмжих тоног төхөөрөмж					
1	Богино долгионы радиостанц	1	1	2	2
2	Түр байршуулах орон байр (майхан, гэр асар)	1	1	1-2	2
3	Цахилгаан үүсгэвэр	1	1	2	2
4	Түргэний автомашин	1	1	1-2	2
	Зөөврийн амьсгалын аппарат	-	-	1	1
	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	1	1	1	1
	Амбу (хэмжээ бүрээр)	1	1	2	2
	Ларигоскоп (хүүхэд, насанд хүрэгч тус бүр)	1	1	1	1
	Интубацийн гуурс (хүүхэд насанд хүрэгч тус бүр)	1	1	1	1
	Хүчилтөрөгчийн дэр	1	1	1	1
	Зөөврийн дефибриллятор	-	-	1	1
	Чигүүд (багц)	1	1	1	1
	Хүзүүний бэхэлгээ (хүүхэд, насанд хүрэгч тус бүр)	1	1	1	1
	Толгойн бэхэлгээ (хүүхэд, насанд хүрэгч тус бүр)	1	1	1	1
	Бүх биеийн бэхэлгээ (хүүхэд, насанд хүрэгч тус бүр)	1	1	1	1
	Хөтөвч	1	1	1	1
	Живх (хүүхэд, насанд хүрэгч тус бүр)	2	2	2	2
	Зөөврийн цахилгаан үүсгүүр	-	-	1	1
	Хяналтын монитор	1	1	1	2
	Зөөврийн отсос	1	1	1	1
Дамнуурга (эвхдэг)	1	1	1	1	

D хавсралт
(норматив)

Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт хийх оношилгооны багц

№	Оношилгооны багц	1-р зэрэглэл	2-р зэрэглэл	3-р зэрэглэл (сум дундын эмнэлэг)
1	Зүрхний цахилгаан бичлэг	+	+	+
2	Хэт авиа оношилгооны аппарат	+	+	+
3	Шээсний хэмжээ ба хувийн жин үзэх (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
4	Шээсний Ph тодорхойлох (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
5	Шээсэнд уураг тодорхойлох (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
6	Шээсэнд эритроцит тодорхойлох (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
7	Нитрат, нитритийн урвал тодорхойлох (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
8	Шээсэнд сахар тодорхойлох (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
9	Шээсэнд билирубин тодорхойлох (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
10	Шээсэнд цагаан эс тодорхойлох (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
11	Шээсэнд кетон тодорхойлох (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
12	Шээсний тунадас микроскопоор шинжлэх	-	+	+
13	Цусанд Креатинин фосфокиназа, КФК (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
14	Цусанд Тропинин Т; Зүрхний булчингийн үрэвслийн маркер (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
15	Хүний бета хорион гонадотропин (өглөөний шээсэнд дүрж үздэг түргэвчилсэн туузан оношлуур)	+	+	+
16	РАР сорил	+	+	+
17	Цусны АВО бүлэг тодорхойлох	+	+	+
18	Цус авч сэлбэх	+	+	+
19	Гемоглобиныг гемоглобинометрээр тодорхойлох	+	+	+
20	Цуснаас түрхэц бэлтгэн Романовский-Гимзийн болон Май-Грюнвальдын аргаар лейкоцитийг ялган тоолох	+	+	+
21	Цусанд эритроцит, тромбоцитийг микроскопоор тоолох	+	+	+
22	Гематокрит	+	+	+
23	С-урвалжит уураг тодорхойлох (түргэвчилсэн оношлуур)	+	+	+
24	Цус урсах хугацаа	+	+	+
25	Идэвхижүүлсэн парциал тромбопластины хугацаа		+	+
26	Цусны сахар – өглөөний өлөн цусанд тодорхойлох	+	+	+
27	Глюкозын зохих тунг өгснөөс 1 ба 2 цагийн дараа цусны сахарыг тодорхойлох	+	+	+
28	Цусан дахь уураг, төмөр, альбумин, холестерин, триглицерид тодорхойлох	+	+	+
29	Креатинин фосфокиназа, КФК	-	-	+
30	Тропинин Т; Зүрхний булчингийн үрэвслийн маркер	-	-	+
31	Билирубин	-	+	+
32	Аланин аминотрансфераз (АЛТ);	-	+	+
33	Аспаргат аминотрансфераз (АСТ);	-	+	+
34	Шүлтлэг фосфатаз (ШФ)	-	+	+
35	Гамма глутамил трансферез (ГГТ)	-	+	+
36	Сийвэнгийн креатинин	-	+	+

37	Шээсний креатинин	-	+	+
38	Амилаз	-	+	+
39	С- урвалжит уураг	-	-	+
40	Улаан эсийн тунах хурд	-	-	+
41	Ходоодны хелико бактерийн түргэвчилсэн шинжилгээ	-	-	+
42	Цэрний сорьц цуглуулах	+	+	+
43	Цэрийг нүдээр харж шинжлэх	+	+	+
44	Цэрнээс наац бэлтгэх	+	+	+
45	Цэрний наацыг Грамын аргаар будаг	+	+	+
46	Грамын аргаар будсан наацыг микроскопт харах	-	+	+
47	Цэрний наацыг Цель-Нильсоний аргаар будаг	-	+	+
48	Цель-Ниелсэний аргаар будсан наацыг микроскопт харах	-	+	+
49	Сорьц авч нүдээр харж шинжлэх	+	+	+
50	Үтрээний арчдасыг микроскопт шууд харах	+	+	+
51	Үтрээний арчдаснаас наац бэлтгэн бэхжүүлж Грамын аргаар будаж микроскопт харах	+	+	+
52	Үтрээний арчдасыг 1 %-ийн КОН уусмалд авч нойтон түрхцээр Gardnerella илрүүлэх	-	+	+
53	Тэмбүүгийн түргэвчилсэн сорил (RPR сорил)	+	+	+
54	ХДХВ/ДОХ-ын түргэвчилсэн сорил	+	+	+
55	Гепатит С вирус илрүүлэх түргэвчилсэн сорил	-	+	+
56	В гепатитын гадаргуугийн эсрэг төрөгч HBsAg илрүүлэх	-	+	+
57	Бруцеллоз/Розе-Бенгалын сорил	+	+	+
58	Далд цус илрүүлэх (Webers-ийн сорил)	+	+	+
59	Баасанд шимэгч хорхойн өндөг илрүүлэх (хошног орчмын энтеробиоз)	+	+	+
60	Арчдасыг микроскопт харж шимэгч хорхойг ялган оношлох	+	+	+
61	Шулуун гэдэсний арчдас авч нойтон түрхцээр Giardiasis оношлох	+	+	+

Е хавсралт
(норматив)

Е1. Эмнэлгийн нэг оронд байх цагаан хэрэгсэл, зөөлөн эдлэлийн хангалт

№	Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн нэр	Хэмжих нэгж	Тоо
1	Гудас	ширхэг	1
2	Гудасны уут	ширхэг	3
3	Дэр	ширхэг	3
4	Дэрний уут	ширхэг	6
5	Ор, хөнжлийн даавуу	ширхэг	3
6	Хөнжил	ширхэг	1

Е2. Эрүүл мэндийн ажилтны хувцас, хэрэглэлийн хангалт (нэг хүнд)

№	Хувцас, хэрэглэл	Хэмжих нэгж	тоо
1	Ээлжийн хувцас (халад, малгай)	ширхэг	3
2	Дүрэмт хувцас (өмд, цамц, углааш)	ширхэг	3
3	Үйлчилгээний ажилтны зориулалтын хувцас	ширхэг	3
4	Хамгаалалтын хормогч	ширхэг	3
5	Гарын алчуур, саван,бусад	1 сарын нөөцтэй байх	
6	Халдаг гудас, хөнжил	Үйл ажиллагааны онцлогоос	
7	Дулаан хувцас, малгай, дах, дэгтий, усны гутал, эсгий гутал, бээлий		